



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: ХААИС, МАЛ ЭМНЭЛГИЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: “МАЛ ЭМНЭЛ ЗҮЙ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР

Индекс: D084101

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Эрдэнэхүү  
Гишүүд: Б.Энхтөр  
Д.Нармандах

2021 оны 01 сар

## Агуулга

<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	4
<b>I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт</b> .....	6
<b>II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга</b> .....	7
<b>III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b> .....	8
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .....	11
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа .....	14
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .....	16
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	20
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа .....	26
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа .....	30
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт .....	35
<b>IV. Уулзалтад оролцогчдын нэрс</b>	
I. Багш нарын нэрс .....	43
II. Оюутнуудын нэрс .....	43
III. Ажил олгогчдын нэрс .....	43
IV. Төгсөгчдийн нэрс .....	44
<b>V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал</b> .....	45
<b>ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b>	
<b>ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b>	

## Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
МЭС	Мал Эмнэлгийн Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
БМИУЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
STEER	Social, Technological, Economic, Environmental, Political analysis Нийгэм, Технологи, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин, Улс төрийн үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга.
D1C	Day One Competence-Шинэ төгссөн малын эмчийн эзэмшсэн байх минимум мэдлэг, ур чадвар
ДМАЭМБ	Дэлхийн Мал Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага
ОУБ	Олон Улсын Байгууллага
OIE	Office International des Epizooties- Дэлхийн Мал Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага
ULMS	University Learning Management System-Их Сургуулийн Сургалтын Удирдлагын систем
УМС	Удирдлагын Мэдээллийн Систем
EAEVE	The European Association of Establishment for Veterinary Education-Европын Мал Эмнэлгийн Сургуулиудын Холбоо (ЕМЭСХ)
ЖСА-ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
КОИСА-КОЙКА	Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага
SDC	Swiss Agency for Development and Cooperation Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлаг
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамд Хятад Ард Улс
ТББ	Төрийн Бус Байгууллага
МонҮМЭХ	Монголын Үндэсний Мал Эмнэлгийн Холбоо

МАЗ	Мал Аж Ахуй
ХХАА	Хүнс Хөдөө Аж Ахуй Хөдөөгийн хөгжлийн яам
РСR	Полимеразын Гинжин Урвал
ХУД	Хан Уул Дүүрэг
Lib4U	Цахим номын сангийн платформ
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
PEOs	Program Educational Objectives Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
PLOs	Program Learning Outcomes Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
CLOs	Course Learning Outcomes Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
ҮДСБ	Үр Дүнд Суурилсан Боловсрол
ISCED-F-2013	Боловсролын олон улсын стандарт ангиллын боловсрол, сургалтын хөтөлбөр, мэргэшлийн чиглэлийн ангилал
ЭЕШ	Элсэлтийн Ерөнхий Шалгалт
ЭША	Эрдэм Шинжилгээний Ажил
ШУТ сан	Шинжлэх Ухаан Технологийн сан
ЭШХ	Эрдэм Шинжилгээний Хурал
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
PDCA	Plan, Do, Check, Act-Төлөвлө, Гүйцэтгэ, Шалга, Сайжруул
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ЭШБ хурал	Эрдэм Шинжилгээний Бага Хурал
ОЗ	Оюутны Зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ӨҮТ	Өөрийн Үнэлгээний Тайлан

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	ХААИС, Мал эмнэлгийн сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	“Мал эмнэл зүй” бакалаврын хөтөлбөр	
<b>Индекс</b>	D084101	
<b>Шинжээчид</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Н.Эрдэнэхүү - ШУТИС-ийн МХТС-ийн дэд захирал, доктор, дэд профессор</li> <li>2. Б.Энхтөр - “Инвест коп Монгол” төслийн хөдөө аж ахуйн мэргэжилтэн</li> <li>3. Д.Нармандах - Мал зүйч, үржүүлэгчдийн холбооны гишүүн, доктор</li> </ol>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Б.Мядагмаа - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2020.12.22.	ХААИС, Мал эмнэлгийн сургуулийн Мал эмнэл зүй хөтөлбөрийн нотлох баримттай сургууль дээр нь очиж танилцсан.
	2020.12.23	Багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөлөлтэй цахим уулзалтуудыг хийсэн
	2020.12.24	Сургуулийн өөрийн үнэлгээний багт цахимаар шинжээчийн үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар танилцуулсан.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1942 онд МУИС байгуулагдахад түүний бүрэлдэхүүнд байсан 3 үндсэн салбарын нэг нь мал эмнэлгийн салбар байсан байна. 1958 онд МУИС-ийн мал эмнэлгийн факультетын суурин дээр Хөдөө Аж Ахуйн Дээд Сургууль байгуулагдаж үндсэн тэнхим нь мал эмнэлгийн факультет байжээ.

2001 оноос ХААИС-ийн Мал Эмнэлэг Биотехнологийн Сургууль байгуулагдаж удирдлага зохион байгуулалт, санхүүгийн хувьд бие даан ажиллах болсон байна. 2002 онд малын их эмч мэргэжлээс гадна мал эмнэлгийн магадлан шинжээч, мал эмнэлгийн эм зүйч, жижиг амьтны эмч зэрэг мэргэжлийн шинэ ангиуд нээж сургалт явуулж эхэлсэн байна. 2014 оноос ХААИС-ийн Мал Эмнэлгийн Сургууль болж өөрчлөгдсөн ба ЮНЕСКО-гоос гаргасан ISCED-F-2013 индексийн дагуу “Мал эмнэл зүй” хөтөлбөрөөр малын их эмч мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг болсон байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гол гол тоон үзүүлэлтийг 2020 оны байдлаар доор үзүүлэв. Үүнд:

- Бакалаврын хөтөлбөр-Мал эмнэл зүй /5 жил , 152 кредит/
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон тоо-2 /2003, 2012/
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд баримталж байгаа үндсэн зарчим:
  - ДМАЭМБ-аас гаргасан төгсөгчийн цогц чадамж (D1C), цөм хөтөлбөр
  - Гадаадын ижил төстэй их, дээд сургуулиудын бодит туршлагыг нэвтрүүлэх /Гадаадын 12 сургуультай харьцуулсан судалгаа/
  - Хөтөлбөрт оролцогч талуудын санал хүсэлтийг тусган, тасралтгүй сайжруулах тогтолцоо
  - Оюутан төвтэй, идэвхтэй, дадлагажуулах сургалтын технологи
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн буюу шинэ төгссөн малын эмчийн эзэмшсэн байх минимум мэдлэг, ур чадвар (day one competence-D1C)
  - Мэргэжлийн суурь-6
  - Ерөнхий ур чадвар-52
  - Тусгай ур чадвар-288
- Сургалтын төлөвлөгөөний хичээл/кредитийн хуваарилалт:
  - Ерөнхий суурь-17/28, 18.4%
  - Мэргэжлийн суурь-22/46, 30.2%
  - Мэргэшүүлэх-38/78, 51.3%
- Сургалтанд ашиглаж байгаа сургалтын болон үнэлгээний аргууд:
  - Сургалтын аргууд-9
  - Хүргэх хэлбэрүүд-8
  - Үнэлгээний аргууд-17
- Сургалтын төлөвлөгөөнд байгаа дадлагын хичээл:
  - Хичээлийн тоо-5
  - Хичээлийн нийт кредит-21
  - Дадлагын үргэлжлэх хугацаа-21 долоо хоног
  - Нийт кредитэд эзлэх хувь-14%
- Ихэрлүүлэх хөтөлбөр/Twinning program/-ийн үр дүн: /2017-2019 он/
  - Хамтарсан сургууль-Японы Хоккайдогогийн их сургууль
  - Хамрагдсан хичээлийн тоо-15
  - Хамрагдсан оюутны тоо-1943
  - Хамрагдсан багшийн тоо-20

- Бакалавр оюутны тоо-922
- Гадаад оюутны тоо-5
- ХААИС-ын хамтарсан хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо-19 /сүүлийн 5 жилд/
- 2019-2020 оны элсэгчдийн тоо-106
- ЭЭШ-ын дундаж оноо-384.7
- Сүүлийн 5 жилд шилжин ирсэн оюутны тоо-212
- Сүүлийн 5 жилд шилжин явсан оюутны тоо-41
- Нэг оюутанд ноогдох зардал-2.523 сая төгрөг
- Төгсөгчдийн тоо-201 /2019/
- Мэргэжлийн ажил эрхлэлтийн хувь-94%
- Төгсөлтийн дараах сургалтад хамрагдагсдын тоо /2019/:
  - Магистрын сургалт-38
  - Докторын сургалт-6
  - Малын эмчийн итгэмжлэл-282
  - Эм зүйн сургалт-25
- Сургалтын орчин, лаборатори, анги танхим:
  - 180 суудалтай лекц заал-1
  - 110 суудалтай номын сан-1
  - Лекцийн танхим-2
  - Семинар, дадлагын кабинет-15
  - Лаборатори-13
  - Мал, амьтны дадлагын бааз-2
- Мэргэжлийн тэнхимийн тоо-4
- Судалгааны профессорын багийн тоо-5
- Нийт багш, ажилтан, ажиллагсдын тоо-89
- Үндсэн багшийн тоо-33
- Эрдмийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь-76.5%
- Гадаад, дотоодод докторантурт суралцаж буй багш нарын тоо-15
- Сүүлийн 5 жилд гадаадад мэргэжил дээшлүүлсэн багш нар-38
- Багшийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд богино хугацааны сургалтад хамрагдсан багш нарын тоо-110 /сүүлийн 5 жилд/
- Профессор багш нарын сүүлийн 5 жилийн ЭША-ын гол үр дүн:
  - Суурь судалгааны төсөл-5
  - ШУТ-ын сангийн төсөл-2
  - Инновацын төсөл-1
  - Гэрээт ажил-4
  - Гадаадтай хамтарсан төсөл-13
  - Имфакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо-36
  - Зохиогчийн эрх/ашигтай загварын тоо-6/6
  - Хэвлүүлсэн сурах бичиг-7
  - Докторын зэргийн нэг сэдэвт бүтээл-5
  - Хэвлүүлсэн ном товхимол-21
  - Гарын авлага-25
  - Эрхлэн гаргасан сэтгүүл, бүтээлийн хураангуй, эмхэтгэл-12
- Хамтран ажилладаг дотоод гадаадын байгууллага, холбоод /2019 оны байдлаар/:
  - Гадаадын байгууллага, сургууль-17
  - Мэргэжлийн холбоо-6

- Үйлдвэр үйлчилгээний байгууллага-2
- Төрийн байгууллага-13
- Төрийн бус байгууллага-8
- Хөтөлбөрийг чадавхжуулах чиглэлээр хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх төслүүд:
  - ШХА-ийн Малын эрүүл мэнд төсөл “Мал эмнэлгийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нь” /2012-2015/
  - ЖАИКА “МАН, Мал эмнэлгийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах” төсөл /2014-2019/
  - АХБ-ны “Дээд боловсролын шинэчлэл” төсөл /2012-2020/
  - ОИЕ “Мал эмнэлгийн боловсролыг хослуулах ” хөтөлбөр /2017-2019/
  - БНСУ-ын ХХААХөдөөгийн хөгжлийн яам, КРС байгууллагын “Мал эмнэлгийн чадавхыг дээшлүүлэх, клиник байгуулах” төсөл /2019-2023/
  - ЖАИКА “МАН, Мал эмнэлгийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах” төсөл /2020-2024/

3 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг хөтөлбөрт үнэлгээ хийсэн бөгөөд дараах давуу талуудыг онцолж байна. Үүнд:

- ✚ 1942 оноос хойш 80 гаруй жил сургалт явуулж ирсэн арвин туршлагатай, салбартай олон шилдэг мэргэжилтэн бэлтгэсэн бахархалтай, багшлах бүрэлдэхүүний чадамж өндөр, мэргэжилтний хэрэгцээ, ажлын байрны эрэлт өндөр байгаа зэргээс харахад цаашид хөтөлбөр тогтвортой хэрэгжих бүрэн боломжтой байна.
- ✚ Швейцарын хөгжлийн агентлаг, JICA олон улсын байгууллагын төслөөр сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, сургалтын орчин, нөөцийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлд маш их хөрөнгө оруулалт хийгдэж, олон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагдсанаар сургалт, эрдэм шинжилгээний чиглэлд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан байна.
- ✚ Хөтөлбөрт оролцогч талуудын санал зөвлөмжийг тусгах, гадаадын ижил төстэй сургуулийн сайн туршлагыг нэвтрүүлэх, дотоодын болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх чиглэлээр удирдлага, хамт олноороо хичээл зүтгэлтэй ажиллаж бусад их, дээд сургууль түгээн дэлгэрүүлж болох олон сайхан туршлага хуримтлуулжээ.
- ✚ Сургалтын үйл ажиллагааг цөөн оюутантай группээр үр дүнтэй зохион байгуулж, идэвхтэй сургалтын 10 гаруй аргыг амжилттай нэвтрүүлсэн байна
- ✚ Сүүлийн жилүүдэд Японы JICA, Швейцарын хөгжлийн агентлаг, Солонгосын KOICA зэрэг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр 9 шинэ лаборатори байгуулснаар орчин үеийн дэвшилтэт техник хэрэгсэл ашиглан сургалт, судалгаа явуулах өргөн боломж бүрдсэн байна.
- ✚ Жишээ нь Мал, амьтны эм болон пестицидийн үлдэгдэл тодорхойлох, хий, шингэний хроматографийн төхөөрөмж, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох аппарат, полимерадын гинжин урвал (PCR)-ын аппарат, дадлагын хичээлийг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах багаж төхөөрөмжүүд, мал, амьтныг орлуулж дадлага хийх муляж, 3D программ хангамж бүхий виртуал лаборатори зэргийг дурдаж болно.
- ✚ Мал, амьтны үзлэг оношилгооны байрыг сургуулийн дэргэд, мөн сургалтын хээрийн дадлага хийх зориулалт бүхий сургалт, судалгааны байрыг ХУД-ийн Өлзийт хороололд тус тус шинээр барьж байгуулсан нь оюутнуудад практик үр чадвар олгоход чухал хувь нэмэр оруулах ажил болсон байна.



- ✚ JICA олон улсын байгууллагын санхүүжилтээр 2015 онд номын сангийн өргөтгөлийг барьж байгуулан, Англи хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийн хангамжийг сайжруулсан байна.
- ✚ Сургуулийн удирдлага гадаад хамтын ажиллагааг маш сайн хөгжүүлж гадаадын 10 гаруй сургууль, байгууллагатай хамтран ажиллаж олон тооны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт татаж чадсан сайн туршлага байна.
- ✚ БСШУСЯ, ШУТС, ШУТИС зэрэг олон байгууллагатай хамтран ажиллаж суурь судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацын чиглэлээр 10 гаруй төсөл, гэрээт ажил хэрэгжүүлж байгаа нь багшийн тоотой харьцуулахад том амжилт гэж үзэж байна.
- ✚ Багш нарын судалгааны, заах арга зүйн, орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Япон, Англи, Непал, Киргизстан, БНХАУ, Герман зэрэг орнуудад урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлэх ажлын зохион байгуулж, олон багш нарыг хамруулж чадсан байна.
- ✚ Эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувь өндөр, багш нар судалгааны болон гадаад хэлний чадвар сайтай, өндөр хөгжилтэй орнуудад эрдмийн зэрэг цолтой хамгаалсан залуу багш нарын тоо нэмэгдэж байгаа нь судалгааны их сургууль болох зорилтод томоохон түлхэц болох нь дамжиггүй.

Магадлан итгэмжлэлийн 7 шалгуурын дагуу хөтөлбөрт үнэлгээ хийсэн дэлгэрэнгүй тайланг дараах бүлгээс уншиж танилцана уу.

---

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- 1942 оноос хойш сургалт явуулж ирсэн ХААИС-ийн анхдагч, арвин туршлагатай салбар бөгөөд 2000, 2002, 2008, 2012, 2014, 2015-2019 онуудад хөтөлбөрийг шинэчилж сайжруулж ирсэн байна.
- Сүүлийн жилүүдэд Швейцарын хөгжлийн агентлаг, ЖАЙКА олон улсын байгууллагын төслөөр хөтөлбөрийг боловсронгуй болгох, сургалтын орчин, нөөцийг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах томоохон ажлууд хийгдсэн байна.
- Хөтөлбөрийг шинэчлэхдээ 3016 малын эмч, 30 багш, 2010-2018 оны төгсөгчид, 315 малчин, 100 гаруй мал эмнэлгийн мэргэжилтнээс санал асуулга авч тусгасан байна.
- Хөтөлбөр боловсруулахдаа мал эмнэлэгтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд, Мерси кор ОУБ-аас МЭС-ийн хөтөлбөрт үнэлгээ хийсэн зөвлөмж, ЕМЭСХ-ноос гаргасан зөвлөмж, ДМАЭМБ-аас гаргасан төгсөгчийн цогц чадамж, Английн хатан хааны МЭС-аас гаргасан шинэ төгсөгчийн цогц чадамжийн зөвлөмж болон ДМАЭМБ-аас гаргасан цөм хөтөлбөр, Английн Хатан хаан, Америкийн Корнел, Швейцарын Берн, Японы Хоккайдо зэрэг их сургуулийн хөтөлбөр, холбогдох бичиг баримтуудыг үндэслэл болгосон байна.
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, чиг хандлагыг тодорхойлохдоо STEEP шинжилгээ хийсэн байна.
- Мөн нийт 12 улсын энэ чиглэлийн хөтөлбөртэй харьцуулж сургалтын үргэлжлэх хугацаа, агуулга, кредит цагийн харьцаа зэрэг үзүүлэлтэд дүн шинжилгээ хийжээ.
- Хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн, үндэсний онцлогийг харгалзан тасралтгүй шинэчлэх чиглэлээр хангалттай олон ажил зохион байгуулагдсан нь тайлан, нотлох баримтаас харагдаж байлаа.

##### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

##### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, оролцогч талуудын санал хүсэлтийг тусгах, гадаадын ижил төстэй их, дээд сургуулиудын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр өргөн хүрээнд ажиллаж, хангалттай туршлага хуримтлуулсныг онцлон, түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Сургалт-судалгаа-инновацыг хослуулан хөгжүүлэх, өрсөлдөх чадвартай мал эмнэл зүйн мэргэжилтэн бэлтгэх зорилго бүхий эрэлт хэрэгцээтэй хөтөлбөр гэж үзэж байна.

##### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн төлөвлөлт хийх, ирээдүйн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо 2012 оны магадлан итгэмжлэлийн байгууллагаас өгсөн санал зөвлөмж, олон улсын

төслүүдийн хүрээнд хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний санал зөвлөмж, оролцогч талуудын санал зөвлөмж зэргийг хэрхэн тусгаж ямар өөрчлөлт сайжруулалт хийгдсэнийг нэгтгэн дүгнэсэн тайлан гаргаж ХААИС, МЭС, багшлах бүрдэлдэхүүн, бусад оролцогч талуудад ойлгомжтой байдлаар тайлагнах талд анхаарч ажиллах.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, МЭС-ийн эрхэм зорилготой уялдуулан, ДМАЭМБ-аас гаргасан төгсөгчийн цогц чадамж D1C-ийг гол чиг баримжаа болгон хөтөлбөрийн боловсролын зорилтуудыг 4 чиглэлээр, хөтөлбөрийн суралцахуйн хүрэх үр дүнг 17 үзүүлэлтээр тус тус тодорхойлсон байна.
- Мал эмнэл зүй хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг бие даан суралцах чадвар, эдийн засаг менежментийн чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, харилцаа ба ёс зүйн чадвар гэсэн 4 үзүүлэлтээр гарган зурагласан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн 17 үр дүн нь мэргэжлийн суурь-6, ерөнхий ур чадвар-52, тусгай ур чадвар-288 гэсэн байдлаар задарч, сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээлүүдтэй холбогдсон байна.
- Төгсөгчийн цогц чадамж D1C-ийг оролцогч талуудаар хэлэлцүүлэн баталгаажуулсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- ДМАЭМБ-аас гаргасан төгсөгчийн цогц чадамж D1C-ийг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн байдлаар зарлан тэдгээртэй уялдаатайгаар сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийг тодорхойлсон нь төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагыг олон улсын түвшинд хүргэхэд түлхэц болно гэж үзэж байна.

### **Анхаарах асуудал:**

- Үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу төгсөгчийн загвар(Graduate attributes), хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs) нь өөр хоорондоо хэрхэн уялдаж байгааг нарийн тодорхойлоогүй байна.
- Мөн PEOs, PLOs нь суралцахуйн үр дүнгүүд учраас заавал үйлийн түвшнийг илэрхийлсэн үйл үгээр илэрхийлэгдэх ёстой.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs) нь төгсөгч тухайн хөтөлбөрөөр төгссөнөөс хойш 4-5 жилийн дараа чадамжийн хувьд ямар түвшинд хүрснийг, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs) суралцагч яг төгсөх үедээ чадамжийн хувьд ямар түвшинтэй болсон байхыг тус тус илэрхийлэх учраас энэ талаас нь харж эдгээр суралцахуйн үр дүнг үйлээр илэрхийлэн зөв тодорхойлох
- PEOs, PLOs буюу суралцахуйн үр дүнгүүдийг оюутны гарын авлага, веб сайт зэрэг мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд түгээж таниулдаг байх.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөрийг хамгийн сүүлж 2019 онд шинэчлэн сайжруулж эрх бүхий нэгжүүдээр хэлэлцүүлэн баталгаажуулсан байна.
- Хөтөлбөрийг БСШУЯ-ны сайдын А/174 тоот тушаалаар баталсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн, ХААИС-ийн захирлын 2014 оны А/427 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам”-ын дагуу боловсруулсан байна.
- Сургалтын төлөвлөгөөний сүүлийн хувилбарыг МЭС-ийн Эрдмийн зөвлөлийн 2019 оны 09 сарын 02-ны хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан мөрдөж байна.
- Мал эмнэл зүй хөтөлбөрийн оюутанд санал болгох төлөвлөгөө болон периодын системийн дагуу гаргасан сургалтын хуанлийг тус тус мөрдөж байна.
- ХААИС-аас гаргасан хичээлийн хөтөлбөрийн загварын дагуу хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулж, хичээл нэг бүрээр тодорхой агуулгын дагуу хавтас үүсгэсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

#### **Анхаарах асуудал:**

- 2019 онд шинэчилсэн сургалтын төлөвлөгөөний хичээлийн харьцаа (18:30:52) байгаа нь БСШУЯ-ны сайдын А/174 тушаалд заасан (30:25:45) харьцаатай бүрэн нийцэхгүй байна.
- Хичээлийн хөтөлбөрт ХААИС-аас гаргасан нэгдсэн загварыг мөрдөж байгаа хэдий ч багш бүр харилцан адилгүй түвшинд, өөр өөр форматаар боловсруулснаас гадна хичээлийн суралцахуйн үр дүнд(CLOs) нь ямар PLOs-той уялдаж байгаа нь хөтөлбөрт тодорхой тусаагүй байна.
- Мөн хичээлийн хөтөлбөрт сургалтын арга зүй, үнэлгээг үр дүнд суурилсан боловсрол талаас нь хэрхэн тусгасан талаар мэдээлэл байхгүй байна.

#### **Зөвлөмж:**

- 2019 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөр нь БСШУЯ-ны сайдын А/174 тушаалын агуулгын дагуу байгаа хэдий ч дэд хэсгүүд нь магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан хэлбэртэй байна. Хөтөлбөр бол сургалтын үйл ажиллагааны циклийг илэрхийлсэн төлөвлөлтийн бичиг баримт учраас энэ талаас харж засаж сайжруулах хэрэгтэй.
- Хичээлийн хавтас бүрдүүлэлтэд хичээлийн хөтөлбөр, лекцийн материалаас гадна лабораторийн заавар, явцын болон улирлын шалгалтын материал, бие даалтын удирдамж, ашиглах ном сурах бичгийн жагсаалт, бусад хэрэглэгдэхүүний талын мэдээллийг бүрэн оруулах, эдгээр бичиг баримтын төлөвлөлтийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу боловсруулах шаардлагатай.

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан](#)**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг суралцахуйн үр дүнгүүд, агуулга талаас нь 2007, 2015, 2019 онуудад тус тус шинэчлэн боловсруулсан байна.
- Өөрийн үнэлгээний тайлангийн хүснэгт 17-д хөтөлбөрийн 17 суралцахуйн үр дүн ба 48 хичээл хоорондын хамаарлын матрицыг гаргасан байна.
- 2015 оноос ХААИС-ийн хэмжээнд сургалтын удирдлага мэдээллийн систем нэвтрүүлж, оюутан хичээл сонголт 1-ээр тухайн улиралд судлах хичээлээ, хичээл сонголт 2-оор хичээл заалгах багшаа сонгох боломж бүрдсэн байна. Мөн 13 кредитийн 5 хичээлийг оюутан өөрөө сонгон судлахаар төлөвлөсөн байна.
- Сургалтын төлөвлөгөөний онол практикийн уялдааг дээшлүүлэх зорилгоор 2013-2014 оны нийт 257 төгсөгчөөс санал асуулга авч, түүнд үндэслэн үйлдвэрлэлийн дадлагын хичээлийн тоог 5 болгон, хичээлийн нийт кредит 21 хүртэл нэмэгдүүлсэн байна. Мөн Өлзийт хороололд байх клиник сургалтын орчныг өргөтгөн сайжруулсан байна.
- Хичээл хоорондын уялдаа холбоог зураг 7 ба хүснэгт 20-д өнгөөр ялган тойм байдлаар үзүүлсэн байна.
- 2015 оноос ХААИС периодын системд шилжсэнээр үндсэн 4, нэмэлт 2 улиралтай болсон байна. Үндсэн улирал бүрийн 8 долоо хоногийн хугацаанд 9 кредитийн 3 хичээл судлахаар ачаалал зохицуулалт хийсэн байна. Суралцагчийн цагийн ачааллыг 7 хоногт 40 цаг байна гэж тодорхойлжээ.

#### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### Анхаарах асуудал:

- Хичээл хоорондын уялдаа холбоог гаргасан хэдий ч суралцахуйн үр дүн талаасаа хичээлүүд хоорондоо ямар хамааралтай байгаа нь тодорхойгүй байна.
- Суралцагчийн цагийн ачааллыг 7 хоногт 40 цаг байна гэж тодорхойлсон хэдий ч энэ бодит байдалд 3 хичээл судлахад хичээлийн кредит, хэлбэрээс хамаарч ямар гүйцэтгэлтэй байхыг тодорхой гаргаагүй байна.

#### Зөвлөмж:

- 2-р хавсралтын 6-р хүснэгтэд байгаа хөтөлбөрийн дэлгэрэнгүй суралцахуйн үр дүнг, 4-р хавсралтын 22-р хүснэгт байгаа шиг сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээл бүртэй нэг бүрчлэн холбож PLOs ба хичээл хоорондын хамаарлыг нарийн гаргах.

### 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мал эмнэл зүй хөтөлбөрт хэрэгжүүлэх сургалтын арга зүй нь харилцан уялдаатай суралцахуйн үйлд тулгуурласан байх зарчмыг баримтална гэж заасан байна. /Зураг 8/.
- 21-р хүснэгтэд үзүүлснээр идэвхтэй сургалтын 10 аргыг 19 хичээл хэрхэн ашиглаж байгаа хамаарлыг үзүүлсэн байна.
- Мөн 4-р хавсралтын 22-р хүснэгтэд зааснаар 8 мэдлэг, ур чадварыг ямар хичээлээр, ямар сургалтын арга зүйгээр олгохыг тодорхойлсон байна.

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)****Анхаарах асуудал:**

- Ерөнхийдөө хөтөлбөрийн онцлогоос хамааран ямар сургалтын аргууд тухайн хөтөлбөрт тохирох, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүй, удирдамж, заавар гаргаагүй байна.
- Хөтөлбөрт ашиглаж байгаа сургалтын арга зүйд дүн шинжилгээ хийж үр өгөөжийг тодорхойлоогүй байна.

**Зөвлөмж:**

- Сургалтын үйл ажиллагаа нь хүрэх үр дүн, сурган заах арга, суралцахуйн үнэлгээ талаасаа харилцан уялдаатай(constructive alignment) байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэл төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх.

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн хэмжээнд оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журмыг 2007, 2012, 2015 онд тус тус шинэчилсэн байна.
- 2015 оноос эхлэн мөрдөж байгаа хичээлийн үнэлгээний систем нь онолын мэдлэг 40%, мэргэжлийн ур чадвар 40%, хувь хүний хандлага ур чадвар 20% гэсэн 3 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд хэсэгт бүрд хэрэглэх үнэлгээний хэлбэрүүдийг тодорхойлж өгсөн байна.
- ХААИС-аас гаргасан “Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх зөвлөмж”-д заасан үнэлгээний рубрикийг үндэслэн хичээл бүрийн үнэлгээний аргыг боловсруулсан байна.
- Мөн 4-р хавсралтын 22-р хүснэгтэд зааснаар 8 мэдлэг, ур чадварыг ямар хичээлээр, ямар сургалтын арга зүйгээр олгох, тэдгээрт ямар үнэлгээний арга зүй хэрэглэхийг тодорхойлсон байна.
- Сургалтын удирдлага мэдээллийн системийн программ хангамжаар хичээл бүрийн дүнгийн тархалтыг тооцож гарган дүн шинжилгээ хийдэг юм байна.

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)****Анхаарах асуудал:**

- Рубрик зэрэг үнэлгээний олон хэлбэрүүдийг ямар ямар суралцахуйн үр дүнг үнэлэхэд ашиглах, тэдгээрийг хэрхэн боловсруулсан талаар мэдээлэл байхгүй байна.
- Хичээлийн үнэлгээнд суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэл талаас нь дүн шинжилгээ хийж, хэрхэн сайжруулах талаар санам зөвлөмж гарган хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

### **Зөвлөмж:**

- Цаашид хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг багш хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүй боловсруулж гарын авлага гаргах, түүнийг багш нарт зааж эзэмшүүлэх, хэрэгжүүлэх шаардлага байна.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан](#)**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургууль хичээлийн 2 давхар нийт 2057.6 м<sup>2</sup> талбай бүхий байртай. Үүнд: лекцийн 3 танхимтай, дадлага, семинарын 15 өрөө, лабораторийн өрөө 13, багш нарын өрөө 16, номын сан 1, эрдмийн зөвлөлийн өрөө 1, оюутны зөвлөлийн өрөө 1, манеж 1, өлгүүр 1, ариун цэврийн өрөө 2 зэрэг нийт 57 өрөө тасалгаатай. Суралцах орчны хүрэлцээ, хангамж сайн байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд тус сургууль нь олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж сургалтын байр, анги танхим, лаборатори, лекцийн болон номын сангийн заалны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, суралцах орчныг сайжруулсан байна.
- Сургуулийн тэнхимүүд урьд өмнө 4 лабораторитой байсан бол сүүлийн жилүүдэд шинээр 9 лаборатори байгуулж нийт 13 лабораторитой болж сургалт, эрдэм шинжилгээний ажилд ашиглаж байна.
- Лабораториуд орчин үеийн өндөр хүчин чадлын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна. Жишээ нь Мал, амьтны эм болон пестицидийн үлдэгдэл тодорхойлох хий, шингэний хромотографийн төхөөрөмж, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох аппарат, полимеразын гинжин урвал (PCR)-ын аппарат зэрэг тоног төхөөрөмжүүд шинээр суурилагдсан байна.
- Сургалт, судалгаанд ашиглах компьютер тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт сайн, сургуулийн дотор, гадна орчны камержуулалт хийгдсэн байна.
- Сургуулийн 1 ба 2 давхрын бүх өрөөнүүд дотоод сүлжээ болон интернэттэй бүрэн холбогдсон. Сургууль орчинд багш, оюутан өөрийн ID эрхээр үнэгүй интернэтэд нэвтрэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Сургуулийн зоорины давхарт оюутан суралцагч, багш ажилчдад үйлчилдэг “Цайны газар” болон хэвлэлийн үйлчилгээ ажилладаг.
- Тус сургуулийн хичээлийн байр нь 1959 онд ашиглалтад орж тасралтгүй 60 гаруй жил ашиглаж байгаа тул зайлшгүй иж бүрэн их засвар хийх, эсвэл шинээр байр барих шаардлагатай байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөцийн хангамж, ашиглалтын талаар оюутан суралцагсдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлт хийдэг байна.

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн удирдлага нь олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж сургалтын байр, анги танхим, лекцийн болон номын сангийн заалны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, суралцах орчныг сайжруулсан байна.
- Сургуулийн лабораториуд мал, амьтны өвчнийг оношлох, эм болон пестицидийн үлдэгдэл тодорхойлох, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох орчин үеийн өндөр мэдрэмжит тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан нь давуу тал байна.

### **Анхаарах асуудал:**

- Лабораториудын бүрэн хүчин чадлын ашиглалт сайнгүй, байнгын үйл ажиллагаа тогтмолжиж жигдрээгүй.
- Орчин үеийн бичил түвшний лабораторийн тоног төхөөрөмжийн инженер байхгүйгээс шаардагдах урсгал засвар үйлчилгээ цаг хугацаандаа хийгдэхгүй байх талтай байна.
- Сургуулийн байрны зарим нэгж хэсгийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, ялангуяа цайны газар, хэвлэх цех, манеж, ариун цэврийн өрөөний орчин нөхцөл сайнгүй, тав тухтай байдал хангалтгүй.
- Сургуулийн хичээлийн байр нь олон жилийн (60 гаруй жил) насжилттайгаас хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, сургалтын байрны стандарт шаардлагыг хангах, маш өндөр өртөг бүхий олон лабораториудын ажиллах орчин, цахилгаан шугам сүлжээ зэргийн баталгаат байдлыг хангахад анхаарах хэрэгтэй байна.

### **Зөвлөмж:**

- Лабораториудын багаж, тоног төхөөрөмжийг сургалт, судалгааны ажилд илүү сайн ашиглаж оюутнуудад мал, амьтны өвчний оношилгоо, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүйн баталгааг лабораторийн шинжилгээний үр дүнгээр батлан харуулах, суралцагсдын сурах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, лабораторид ажиллах ур чадварыг сайжруулах
- Нэр бүхий лабораториудыг албан ёсны баталгаажуулах эрхтэй болгох үүднээс Стандарт хэмжил зүйн газар, Үндэсний итгэмжлэлийн төв болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаар тохирлын үнэлгээ, баталгаажуулалт хийлгүүлж “Итгэмжлэгдсэн лаборатори” -ийн эрхтэй болох
- Өндөр хүчин чадлын баталгаажуулах түвшний лабораториудыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах, сургууль, тэнхимд орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор “Бизнес төлөвлөгөө” боловсруулж ажиллах
- Сургуулийн цайны газар, хэвлэх цех, манежны өрөөнд засвар үйлчилгээ хийж агааржуулалт, эрүүл ахуйн шаардлага, орчин нөхцөлийг сайжруулах
- Сургуулийн ариун цэврийн өрөөнд иж бүрэн засвар хийж эмэгтэй, эрэгтэйгээр нь тусгаарлах, агааржуулалт болон угаалтуур нэмэгдүүлж, эрүүл ахуйн орчин нөхцөл, тав тухтай байдлыг хангаж сайжруулах
- Цаашид тус сургуулийн хичээлийн байранд иж бүрэн их засвар хийх, эсвэл шинээр хичээлийн байр барих асуудлыг төр засгийн бодлогын түвшинд тавьж шийдвэрлэх



### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа нь өөрийн үнэлгээний тайланд тусгасантайгаа таарч тохирч байна. Тухайлбал, сургууль 2019/2020 онд лабораторийн хичээлийн эм урвалжид 13.8 сая, бичиг хэрэгт 1.5 сая, цэвэрлэгээ 1.3 сая төгрөг зарцуулсан байна.
- Суралцагчдад дадлагын хичээлийг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулахад зөөврийн рентген аппарат иж бүрдлээр, мал, амьтныг орлуулж дадлага хийх муляж, 3D программ хангамж бүхий виртуал кабинетаар хангагдсан байна.
- Оюутнуудад практикийн дадал, ур чадвар олгохын тулд сургуулийн дэргэд “Үзлэг оношилгооны байр” шинээр барьж 50 толгой хонь, ямаа, адуу, үхэр байршуулан танхимын өдөр тутмын клиник сургалтын дадлагад ашигладаг байна.
- Мөн сургалтын хээрийн дадлага хийх зориулалт бүхий байрыг ХУД-ийн Өлзийт хороололд шинээр барьж байгуулсан байна.
- Сургуулийн оюутнуудад зориулан тусад нь өрөө гарган шинээр “Оюутны хөгжлийн төв” байгуулж ширээ, сандал, шүүгээ, компьютер, принтер зэрэг техник хэрэглэлээр ханган тохижуулж оюутнуудын суралцах орчныг бүрдүүлж үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж зэрэг баримт бичгүүдтэй. Жишээ нь сургалт, үйлдвэрлэлийн 4 төрлийн дадлагын удирдамж, хөтөлбөрүүдтэй.
- Сүүлийн 2 жилд мэргэжлийн хичээлүүдийг Google Classroom ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Багш бүр цахим журнал хөтлөх, цахим сургалт, сорил шалгалт, бие даалтын ажил, хэлэлцүүлэг хийх зэрэг ажлуудыг цахимаар гүйцэтгэж байна.
- Мэргэжлийн хичээлүүдийн тараах материалуудыг онлайн болон бичлэг хэлбэрээр харуулах байдлаар сургалтад ашигладаг болсон байна.

#### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### Онцлог зүйл/Туршлага:

- Мал эмнэлгийн сургалтад орчин үеийн технологийн шинэ шийдэл, программ хангамж нэвтрүүлсэн. Жишээ нь мал, амьтны анатоми, бие бүтцийн зохион байгуулалт, араг яс, булчин, мэдрэл, зүрх судас, амьсгал, тэжээл боловсруулах, үржил зэрэг эрхтэн системийг бүхэлд нь өнгөт 3D программ хангамжийн ашиглан сургалт явуулах шинэ технологийг анх тутам нэвтрүүлж виртуал кабинет ашиглаж байгаа нь нэн онцлог, сайн туршлага байна.
- Мал, амьтны бэртэл, ясны хугарал зэргийг баталгаатай оношлох рентген аппарат (X-Ray), амьтны элэг, дэлүү, бөөр зэрэг цуллаг болон бусад эрхтний өвчин эмгэгийг оношлох ЭХО аппарат зэргийг малын эмч бэлтгэх сургалт болон судалгааны ажилд нэвтрүүлсэн нь сургалтын чанарт нөлөөлөх ач холбогдолтой ажил болсон байна.
- Оюутны “Хээрийн дадлагын сургалт, судалгааны төв” шинээр байгуулснаар тус сургууль өөрийн гэсэн дадлагын баазтай болсон нь сайн байна.

#### Анхаарах асуудал:

- Хичээлийн бус үед оюутнууд бие даан суралцах байр орчны хангамж дутмаг, шинээр байгуулсан “Оюутны хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаа тогтмолжоогүй байна.

**Зөвлөмж:**

- Сургуульд оюутны бие даан суралцах орчныг илүү нэмэгдүүлж “Оюутны хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж байнгын үйл ажиллагаатай болгох.

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургууль 2015 онд номын санг өргөтгөж шинээр барьж ашиглалтад оруулсан. Нийт 110 суудалтай, орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.
- Номын санд оюутнуудын сурах, бие даалт, даалгавар, судалгааны ажил хийх, интернэт ашиглах, өөрийгөө хөгжүүлэх зэрэгт зориулсан 28 компьютер ашигладаг.
- Ном, сурах бичиг, гарын авлагын хангамж хүрэлцээ сайн байна. Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаатай.
- Монгол хэл дээр мэргэжлийн ном, гарын авлага шинээр боловсруулж хэвлүүлэн сургалтад ашиглаж байна.
- Англи хэл дээр орчин үеийн ном, сурах бичиг, гарын авлагын хангамж эрс сайжирсан. Ялангуяа багш нар сургалтад өргөн ашигладаг болсон байна. Жишээ нь: Японы JICA төслийн санхүүжилтээр мэргэжлийн 44 нэр төрлийн 155.6 сая төгрөгийн сүүлийн үеийн ном, сурах бичгийн хангалт хийжээ.
- 2014 оноос хойш 6 жилийн турш жил бүр 369-708 ном, сэтгүүл шинээр худалдан авч баяжилт хийсэн байна.
- Одоогоор МЭС-ийн номын санд 14296 ном, сурах бичигтэй. Мөн ХААИС-ийн 167.475 боть ном бүхий төв номын санг ашигладаг.
- Номын сан цахим мэдээллийн хэлбэрт бүрэн шилжсэн. 2015 оноос эхлэн Lib4U программыг ашиглаж Улсын төв болон Нацагдоржийн номын сан ШУТИС, МУИС, МУБИС, СЭЗИС зэрэг сургуулиудаас электрон хайлт хийх, олон улсын томоохон цахим сайтуудыг ашиглах боломжийг бүрдүүлж өгсөн байна

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)****Онцлог зүйл/Туршлага:**

- 2015 онд сургуулийн номын санг өргөтгөж шинээр барьж ашиглалтад оруулан орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.

**Анхаарах асуудал:**

- Багш, оюутнууд ашиглах e-book буюу цахим номын хүрэлцээ хангамж тааруу. Цахим санд монгол хэл дээр бичигдсэн 79 ном байна.
- Оюутнууд цахим номын санд хэрхэн нэвтэрч ашиглах талаар мэдлэг, чадвар сул байна. Заавар, зөвлөмж дутагдалтай. Номын сангийн компьютерүүдээс зарим нэг нь эвдэрч, гацдаг болсон байна.

**Зөвлөмж:**

- Цаашид цахим номын фондыг 2015 оноос хойш хэвлэгдсэн, мэргэжлийн чиглэлийн Ангил хэл дээр цахим номоор баяжуулах,
- Профессор багш нар гадаадын их дээд сургуулиудад ашигладаг сонгодог сурах бичгийг Монгол хэл рүү орчуулж сургалтад ашиглах талд анхаарах

- Номын санч болон багш нар оюутнуудад цахим ном хэрхэн ашиглах талаар сургалт өгч, заавар зөвлөмжөөр хангах

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан](#)**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Мал эмнэлэг, биотехнологийн сургууль нэртэй 5 тэнхимийн бүрэлдэхүүнтэй байсан бол ХААИС-ийн захирлын 2014 оны А/202 тоот тушаалаар Мал эмнэлгийн сургууль нэртэй, 4 тэнхимийн бүрэлдэхүүнтэй болж өнөөг хүртэл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг ХААИС-ийн сургалтын бодлого, зохицуулалтын албаны дэргэдэх Хөтөлбөрийн ерөнхий хорооны удирдлага дор салбар сургуулийн сургалтын алба, хөтөлбөрийн эрхлэгч, мэргэжлийн 4 тэнхим хэрэгжүүлэх бөгөөд сургалтын албаны дэргэдэх Мал эмнэл зүй бакалаврын хөтөлбөрийн хороо, Заах арга зүйн зөвлөл хөтөлбөрийн явц, сайжруулалт, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Хөтөлбөрийн бие даасан байдал, мэргэжлийн удирдлага, хөтөлбөрийн хяналт, хэрэгжилтийг сайжруулах, ажил олгогчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанартай төгсөгчдийг бэлтгэх стратегийн зорилтын хүрээнд 2018 онд ХААИС-ийн захирлын А/58 тоот тушаалаар Мал эмнэл зүйн бакалаврын хөтөлбөрийн хороо байгуулагдан хөтөлбөрийн бодлого, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Суралцагчдын гомдол, саналыг сургалтын албаны дэргэд байнга байршуулсан санал хүсэлтийн хайрцгаар дамжуулан авч, сургалтын албаны ажилтан холбогдох тэнхим, сургалтын алба, захиргааны зөвлөлд танилцуулан шийдвэрлэх зарчмаар ажилладаг. Сүүлийн 5 жилийн байдлаар санал хүсэлтийн хайрцгаар 24 санал хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд энэхүү хайрцгаар авсан санал нь биечилж буюу өргөдөл хэлбэрээр гаргасан санал хүсэлтийн тоотой харьцуулахад харьцангуй цөөн байгаа нь оюутанд өөрийн эрх, үүрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлан таниулах, сурах арга барилд суралцах зэрэг асуудлаар зөвлөх багш, тэнхим анхаарч ажиллах шаардлагатай байгаад дүн шинжилгээ хийсэн.
- Жил бүрийн төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгаа авдаг бөгөөд 2019 онд 1-4 ангийн оюутнуудын дунд явуулсан санал асуулгад дүн шинжилгээ хийсний дагуу багцад суурилсан хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хичээлийн уялдаа холбоо, багшийн ачаалал, ур чадвар олгоход гарч буй зарим хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэхийн тулд JICA ОУБ-тай хамтран хөтөлбөрийг боловсронгуй болгох төслийг хэрэгжүүлж эхлээд байна.
- ХААИС 2010 онд сургуулийн урт хугацааны стратеги төлөвлөгөөний баримт бичиг болох “ХААН КАМПУС” хөтөлбөр, “ХААИС-ийг 2028 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн баг дээрх урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд богино хугацааны буюу жилийн төлөвлөгөө боловсруулан ажилладаг бөгөөд энэ нь МЭС-ийн хувьд зөвхөн нэг хөтөлбөр хэрэгжүүлдэг тул тус сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөний

бүрэлдэхүүн хэсэгт багтан ХААИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, үүний дагуу тухайн жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилладаг байна.

- 2015-2016 оны хичээлийн жилээс “Лут систем” ХХК-ийн “ULMS” буюу University Learning Management System-ийг хэрэглэж байна. Энэ УМС-ийг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн удирдлага, багш, оюутан, санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоонд орж үйл ажиллагааны уялдаа хангагдахын зэрэгцээ, явцын бүх мэдээллийг цаг алдалгүй программаас харах боломж бүрдэж, сургуулийн санхүүгийн асуудал нийтэд нээлттэй болохын зэрэгцээ байгууллагын дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж, орон зай, цаг хугацаанаас үл хамааран ажлын бүтээмжийг дээшлүүлэн, байгууллагын мэдээллийн нэгдсэн баазыг бий болгож байна. Тус программ хангамж нь элсэлт, бүртгэл, хичээл бүрдүүлэх, цахим журнал, онлайн шалгалт, санал асуулга, хэлэлцүүлэг, дүн оруулах, тайлан репорт, төгсөлтийн баримт бичиг, хичээлийн хуваарь, багш сонгон шалгаруулалт зэрэг 11 модультай бөгөөд сургалтын менежерийн, багшийн, оюутны программ хангамж гэсэн 3 дэд модультай.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн хөгжлийг урт хугацаанд хангах стратеги төлөвлөгөө, эрхэм зорилгын хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо бэхжиж, урт хугацаандаа уг хөтөлбөр тогтвортой хэрэгжих үндэс суурь бий болсон байна.
- Хичээл нэг бүрийг судалж дууссаны дараа дүн гарахаас өмнө хөтөлбөрт оролцогч тал буюу оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг онлайнгаар авдаг болсон нь хөтөлбөрийг цаашид сайжруулах, удирдан зохион байгуулахад тус дөхөм болж байна.

**Анхаарах асуудал:**

- УМС-д хөтөлбөрийн оролцогч тал буюу төгсөгчдийн линкийг оруулж өгөх, төгсөгчидтэй эргэх холбоог бэхжүүлэхэд удирдлагын зүгээс анхаарах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг сайжруулах, удирдах чиглэлд хөтөлбөрийн оролцогч тал буюу ажил олгогчдыг оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сүүлийн 5 жилд ХААИС-ийн “Оюутан төвтэй судалгааны их сургууль болох” зорилтын хүрээнд гадаадын 6 орны ижил мэргэжлийн нийт 22 их дээд сургууль, коллеж, мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх, багш солилцоо хийх замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх, сургалт, судалгааны орчныг сайжруулах, ижил мэргэжлийн хөтөлбөрийг ихэрлүүлэх болон загвар болгох замаар хөтөлбөрийг

олон улсын жишигт нийцүүлэх, оюутан солилцоо хийх замаар оюутны хөгжлийг дэмжих, сайжруулах ажлууд хийгдэж байна.

- Сүүлийн 5 жилд гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаадын 13 сургууль, байгууллагатай 30 төсөл хэрэгжүүлж 24.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн судалгаа гаргасан.
- Сүүлийн 5 жилд БСШУСЯ, ШУТИС зэрэг байгууллагатай 5 суурь судалгаа, 9 шинжлэх ухаан, технологийн төсөл, 3 инновацын төсөл хэрэгжүүлэх хамтын гэрээ байгуулан ажилласан байна.
- Сурлагын голч, гадаад хэлний мэдлэгийн тодорхой шалгуур давсан оюутнуудад мэргэжлийн хос хөтөлбөр санал болгодог. ХААИС-аас гадна ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг орнуудын хос дипломтой төгсөж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх мэргэжилтэн болох боломжтой. Мөн 2 их сургуулийн гэрээний дагуу харьцангуй бага зардлаар техник технологи өндөр хөгжсөн оронд дадлагажих, дээд боловсрол эзэмших боломжтой.
- 2015 оноос хойш гадаадын их, дээд сургуулиудад 8 докторант сурч байна. Малын их эмч мэргэжлийн ангиас сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл хос хөтөлбөрөөр нийт 19 оюутан суралцахын зэрэгцээ тухайн улс орны МАА салбарын хөгжил, үйл ажиллагааг сурталчлан таниулж ажилласан байна.
- Багш нарын гадаадад урт, богино хугацаагаар суралцсан, мэргэжил дээшлүүлсэн судалгааг гаргасан. Хөтөлбөрийг сайжруулах, заах арга зүй, мэргэжлийн хичээлүүдээр онолын мэдлэг, ур чадвар олгох, лаборатори ашиглалтыг сайжруулах чиглэлээр Английн хатан хааны их сургууль, Японы Хокайдогийн их сургуулийн нийт 6 профессор багш нийт 3 удаа, 2-14 хоногийн хугацаатай ажиллажээ. 27 багш, 5 туслах ажилтан Япон, Англи, Непал, Киргизстан, БНХАУ, Герман зэрэг улсад урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлжээ.
- Тайлангийн хугацаанд ХААИС-ийн хэмжээнд нээлттэйгээр зарлагдан хэрэгждэг судалгааны тэтгэлгийг тус сургуулийн 4 багш хүртсэний дээр улсын хэмжээнд болон аймаг, орон нутаг, бусад ТББ, сангаас зарладаг бакалавр оюутны тэтгэлгийг 33, ХААИС-ийн ректорын нэрэмжит тэтгэлгийг 50 оюутан, оюутны хөгжлийн зээлд 36, төрийн сангийн буцалтгүй тусламжид 149, замын зардлын хөнгөлөлтөд 813 оюутан тус тус хамрагджээ.
- Хэрэгжүүлж буй мал эмнэл зүй хөтөлбөрөөр БНХАУ, Лаос улсын 5 оюутан суралцаж байна.
- Жил бүр БНСУ-ын Chonbuk, Jeju-ийн их сургуулийн нийт 28 оюутан 8-10 багш тус сургууль дээр 14 хоногийн хугацаатай клиник дадлага хийдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч МЭС-ийн хамт олон жил бүр хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран мэргэжлийн чиглэлийн сургалтуудыг зохион байгуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажилладаг. Хүснэгтээс харахад багш нар жилдээ 40 гаруй мэргэжлийн зөвлөгөө өгөх сургалтуудыг явуулж байгаа бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн 4 тэнхимийн хамт олны зохион байгуулж буй мэргэжлийн зөвлөгөө өгөх сургалтууд жил бүр өсөн нэмэгдэж байна.
- Уг мэргэжлээр суралцан төгссөн малын эмч нарын байгуулсан МонҮМЭХ, Монголын жижиг амьтны малын эмч нарын холбоо, Малын эмч, эм зүйчдийн нэгдсэн “Тун 5 эрдэнэ” холбоо, Монголын нэгдсэн хувийн мал эмнэлгүүдийн дундын хороо, Малын эмч нарын “Залуу үе холбоо”, Эрдмийн ундраа-98 төгсөгчдийн сан зэрэг ТББ, холбоод үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс улсын хэмжээнд малын эмч нарын дуу хоолой болж, нийгмийн оролцоог хангахад голлох чиг үүрэг бүхий ТББ нь Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо юм.
- Хамтын ажиллагаатай мэргэжлийн холбоод дотроос Монголын нэгдсэн хувийн мал эмнэлгүүдийн холбоо малын эмчийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр идэвхтэй ажиллагаа явуулдаг бөгөөд тус холбооны сүүлийн 5 жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргасан байна.

- “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-аар шинээр төгсөгч малын эмчид 3 жилийн хугацаатай итгэмжлэл олгодог, цаашид 5 жил тутамд хөтөлбөрт хамрагдаж итгэмжлэл авна. Иймээс тус хөтөлбөрт төгсөлтийн дараах сургалт тогтвортой хэрэгжих эрх зүйн орчин бүрдсэн давуу талтай. Энэхүү сургалтын мэргэжлийн тэргүүлэх холбоо болох МонҮМЭХ-той хамтран бусад мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулдаг.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн удирдлага гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч гадаадын 10 гаруй сургууль, байгууллагатай хамтран ажиллаж олон тооны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт татаж чадсан сайн туршлага байна.

**Зөвлөмж:**

- МЭС-ийн Төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.
- Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нийгэмд байгаа бодит асуудлуудыг шийдэхэд багш, оюутнуудыг татан оролцуулах талд анхаарах.

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн төсөв нь ХААИС-ийн нэгдсэн төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч МЭС-ийн төсвөөс санхүүждэг болно. МЭС-ийн төсөв нь сургалт болон бусад нэмэлт орлогоос бүрддэг. Энэ нэмэлт орлогын дийлэнх хувийг уг хөтөлбөрөөр суралцагчийн хүсэлтээр явагддаг дахин судлах сургалтын төлбөр эзлэх бөгөөд сүүлийн жилүүдэд мэргэжлийн сургалт, бусад орлого нэмэгдэх хандлагатай байна.
- Нэг оюутанд ногдох зардлыг тухайн жилийн нийт төсвийн зардлыг жил бүрийн оюутны тоонд харьцуулан тооцсон бөгөөд 2017 оноос хойш тогтвортой өссөн үзүүлэлттэй байна. Нэг оюутанд зарцуулах өртөг зардлыг сүүлийн 3 жилээр авч үзэхэд 2016-2017 оны хичээлийн жилд 1.837.6 мян төгрөг, 2018-2019 оны хичээлийн жилд 2.522.8 мян төгрөг болж 37 хувиар нэмэгджээ. Оюутанд чиглэсэн үндсэн үйл ажиллагааны зардал өссөн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүгийн үндэс нь сургалтын төлбөр байх бөгөөд санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох зорилтын хүрээнд сургуулийн тэнхим, профессорын баг, багш бүр төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх замаар тодорхой хэмжээний санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг бий болгосон. 2015-2019 онд 2.347.8 сая төг орлого олсон байна. Тус сургуулиас сүүлийн 5 жилд орон нутаг болон нийслэлд 3 удаа “Мал эмнэлгийн техникч бэлтгэх” сургалтыг зохион байгуулж нийт 36 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.
- Тус сургууль Төв аймгийн Эрдэнэ суманд 380 (2019 оны байдлаар) толгой бог мал бүхий сургалт, судалгааны зориулалттай аж ахуй эрхэлдэг бөгөөд эндээс жил бүр ноос, ноолуур зах зээлд нийлүүлж сүүлийн 5 жилд 20 сая төгрөгийн орлого олжээ.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэл өөрчлөлтөд зориулсан дотоод, гадаад эх үүсвэрээс санхүүжигдсэн төсөв жил бүр нэмэгдэж, нийт төсвийн дийлэнх хувийг сургалттай холбоотой шууд ба шууд бус зардал, хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа нь сайн үзүүлэлт юм.
- Төгсөлтийн дараах сургалт, бусад хөтөлбөрөөс орох орлого нэмэгдсэн. Сүүлийн 3 жилээр авч үзвэл нэг оюутанд зарцуулах зардал 37 хувиар нэмэгдэж, оюутанд чиглэсэн үндсэн үйл ажиллагааны зардал өссөн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Олон улсын байгууллагуудаас санхүүжигдсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг нарийн тооцож үр ашгийг оновчтой ашиглахад анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Өөрсдийн сургалт, судалгааны ажил, төсөл, хөтөлбөрөөс олох орлогыг нэмэгдүүлж, санхүүгийн тооцоог нарийвчлан төлөвлөх замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах санхүүгийн олон эх үүсвэртэй болоход анхаарах.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрт 2015 онд ЕМЭСХ хөндлөнгийн үнэлгээ хийсэн бөгөөд энэ үнэлгээний дүнг үндэслэн Монголын мал эмнэлгийн эрэлтийг судалж, үүндээ тулгуурлан мэргэжилтэн бэлтгэх, улмаар малын эмч бэлтгэж буй сургалтын чанарыг сайжруулахад анхаарч иржээ.
- 2015 оноос малын эмч мэргэжилтний хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлага, мал эмнэлгийн үйлчилгээ, энэ мэргэжлээр элсэгч, төгсөгчдийн сүүлийн 10 жилийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд тус тус үндсэн сургалтын үндсэн баримт бичгүүдээ шинэчилсэн байна.
- ХААИС-ийн хэмжээнд мэргэжил сурталчлах, ЕБС төгсөгчдийн мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох улмаар элсэгчдийн тоог тогтвортой хадгалж хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах үүднээс ХААИС-ийн захирлын 2015 оны А/61 тоот тушаалаар “ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь ХААИС-ийн үйл ажиллагаа, эрдэмтэн багш, судлаачдын бүтээлийг олон нийтэд хүргэх, мэргэжлүүдийг зах зээлд сурталчлах, сонирхогч, оролцогч талуудтай харилцаа холбоогоо хөгжүүлэх замаар нийгэмд ХААИС-ийн эзлэх байр суурийг нэмэгдүүлэх үндсэн зорилгыг агуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд зорилтот зах зээлд чиглэсэн төлөвлөгөөт арга хэмжээ бүхий дэд хөтөлбөрүүдтэй. Тус хөтөлбөрийн хүрээнд МЭС-аас зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийг жагсаалтаар гаргасан.
- Эдгээр төлөвлөгөөт ажлуудаас гадна мал эмнэлгийн салбарын төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Малын их эмч мэргэжлээр төгсөгчдийн нэлээд хувь нь төрийн мал эмнэлэгт ажилладаг бөгөөд дээрх байгууллагуудыг түшиглэн маркетингийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжийг олгодог.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Мал эмнэл зүй” хөтөлбөрийн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулсан нь сайшаалтай.

#### **Анхаарах асуудал:**

- “Мал эмнэл зүй” хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөний явцын тайланг гаргаж хэрэгжилтэд хяналт тавих тал дээр анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн нээлттэй ил, тод байдлыг хангах, мэргэжлийн ач холбогдол, нийгэмд эзлэх байр суурь, давуу талыг нийтэд таниулахад чиглэсэн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх, үүнд мэдээллийн технологийн хөгжлийн ололтыг ашиглах бодлого баримтлах.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тус сургуулийн профессор багш нар ажлын туршлага, мэргэшил, судалгааны ажлын туршлага, чиглэл, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр зэрэгт түшиглэн хөтөлбөрийн гол хэрэглэгдэхүүн болох бүтээлүүдийг бүх шатны суралцагчид, төгсөгчид, мэргэжилтнүүдэд зориулан боловсруулж, нийтийн хүртээл болгодог бөгөөд тайлангийн хугацаанд боловсруулсан бүтээлийн судалгааг гаргасан бөгөөд бүтээлийн төрөл, тоон үзүүлэлт нэмэгдэж сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд сайнаар нөлөөлж байна.
- ХААИС-ийн [muls.edu.mn](http://muls.edu.mn) албан ёсны веб сайт нь бүтэц, агуулгын хувьд сургуулийн олон талт үйл ажиллагааны талаар мэдээллийг түгээх зорилготой бөгөөд үндсэн болон туслах цэсээр мэдээллийг ангилан хүргэдэг.
- ХААИС-ийн захиргааны бүтцийн нэгж болох мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн 3 ажилтан бүхий Мэдээлэл технологийн алба тус сургуулийн веб болон УМС-ийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг.
- МЭС-ийн веб сайтад ХААИС-ийн үндсэн веб сайтаас холбоосоор дамжиж болон [veterinary.muls.edu.mn](http://veterinary.muls.edu.mn) хаягаар шууд хандах боломжтой.
- Сургуулийн веб сайт өнөөдрийн байдлаар үйл ажиллагааны тогтвортой байдал, мэдээллийг тогтвортой шинэчлэх тал дээр учир дутагдалтай байгаа нь вебийг мэдээллээр хангах бүтцийн нэгжүүд, нөгөө талаас веб хариуцсан мэргэжлийн ажилтан дутагдалтай байгаа зэргээс шалтгаалсан боловч 2019 оноос бүх салбар сургуулийн вебийг шинэчлэх ажлыг ХААИС-ийн Мэдээлэл технологийн алба хариуцан хэрэгжүүлж эхлээд байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй ил тод түгээх талаар хийж буй олон талт ажлууд тайлангийн бусад хэсэгт харагдаж байгаа бөгөөд үүнийг нэгтгэж дүгнэх, системтэй болгон бичих тал дээр анхаарах

#### **Зөвлөмж:**

- Одоо шинэчлэн боловсруулж буй сургуулийн веб сайтад төгсөгчдийн холбооны холбоосыг нэмж оруулж, уг линкээр дамжуулан төгсөгчдийг сургууль, мэргэжлийн талаарх мэдээллээр хангах замаар хөтөлбөрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх.



- Хөтөлбөрийн ил тод байдлыг хангах, мэргэжлийн ач холбогдол, давуу талыг олон нийтэд сурталчлан таниулах ажилд багш, тэнхим, нэгж бүрийн оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган дүгнэдэг байх.

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: [Бүрэн хангасан](#)**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- БСШУСЯ-ны 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ын 1.11 дэх заалт, ХААИС-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг үндэслэн оюутан элсүүлдэг.
- 2015 оноос их сургуулиас зорилтот элсэгчдийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд “ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Мэргэжлээ сурталчлах “Мэргэжил миний ирээдүй”, “Элсэлтийн нээлттэй мэдээлэл”, “ХААИС-ийн элч оюутан” зэрэг ажлуудыг тогтмол хийж ирсэн.
- Уг хөтөлбөрөөр 2015-2019 оны хооронд 811 оюутан элссэн ба 2015-2016 оны хичээлийн жилд хамгийн олон буюу 219, 2019-2020 оны хичээлийн жилд хамгийн бага буюу 106 элссэн нь тухайн жилд ЕБС-ийн хамгийн бага төгсөгчтэй жил байсантай холбоотой.
- ХААИС-д Оюутан элсүүлэх журмын 1.5-д “ХААИС нь Хөдөө аж ахуйн салбар, хөдөөгийн хөгжлийн шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэлийн тулгуур төвийн хувьд орон нутгаас оюутан түлхүү элсүүлэх бодлогыг баримтална” гэсэн заалтын дагуу нийт элсэгчдийн 97.18 (707) хувийг орон нутгаас 2.82 (80) хувийг УБ хотоос элсүүлсэн.
- ХААИС, бүрэлдэхүүн сургуулиас оюутны гарын авлага, оюутны хөгжил хөтөлбөр, мал эмнэл зүйч хөтөлбөрийн эмхэтгэл, мэргэжлийн болон мэргэшүүлэх суурь хичээлийн гарын авлага, мэргэжлийн англи хэлний толь бичиг өгдөг. ХААИС-ийн оюутны гарын авлага нь Сургалтын бодлого зохицуулалтын албанаас эрхлэн гаргадаг шинээр элссэн оюутнуудад зориулсан эрх зүйн баримт бичиг болно. Гарын авлага нь агуулгын хувьд үндсэн 4 бүлэгтэй, сургалтын төлөвлөгөө, сургалттай холбоотой дүрэм, журам, оюутанд үзүүлэх үйлчилгээ, спортын секц, дугуйлан, сайн дурын клубүүдийн танилцуулга зэрэг цогц мэдээлэл багтсан байдаг.
- Уг хөтөлбөрөөр 2015-2019 онд Лаос улсаас 3, БНХАУ-аас 2 нийт 5 оюутан суралцаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэлтийн талаарх мэдээллийг [www.muls.edu.mn](http://www.muls.edu.mn), [www.elselt.muls.edu.mn](http://www.elselt.muls.edu.mn) портал сайтаас өгч ажилладгаас гадна ХААИС-аас ЕБС-иудад мэргэжил, сургууль сурталчлах танилцуулах өдөрлөгийг жил бүрийн 4, 5-р сард зохион байгуулж, радио, телевиз, сониноор болон МЭС-ийн [veterinary@muls.edu.mn](mailto:veterinary@muls.edu.mn) сайтаар явуулдаг.
- Нийт элсэгчдийн 97.18 (707) хувийг орон нутгаас элсүүлсэн онцлогтой.

### **Зөвлөмж:**

- Элсэгчдийн чанарыг дээшлүүлэх зорилгоор ХААЯ, БШУЯ-тай хамтран ажиллаж бодлогын дэмжлэг авах талд санаачилга гарган ажиллахад анхаарах.
- Малын бага эмч бэлтгэх сургуулиас ахисан түвшинд буюу МЭС-д элсүүлэн суралцуулах чиглэлээр зах зээлийн судалгаа явуулж элсүүлэх, дүйцүүлэн суралцуулах тусгай бодлого, журам боловсруулах

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан уг хөтөлбөрөөр суралцагч оюутанд үйлчилгээ үзүүлэх алба нэгжүүд нь “Чанартай сургалт - сэтгэл ханамжтай оюутан” гэсэн уриан дор 6 чиглэлээр 24 төрлийн үйлчилгээг тогтмол үзүүлж байна.
- ХААИС, бүрэлдэхүүн сургуулиас оюутан суралцагчдын суралцах үйл ажиллагаанд үйлчилгээний орчин үеийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд тэдний бие даан хөгжих, амьдрах, суралцах таатай орчныг бүрдүүлэх үүднээс “Оюутны хөгжил хөтөлбөр”, “ХААН кампус” хотхон, “Экологийн цэвэр орчин” зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж оюутанд үйлчлэх “Оюутны хөгжил төв”, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулж, оюутны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган батлуулж ажиллаж ирсэн.
- “ХААИС-ийн Оюутны хөгжил хөтөлбөр” бодлогын баримт бичгийг 2019 онд боловсруулан батлуулсан ба энэ хөтөлбөрт:
  - Бүтээлчээр сэтгэгч, шинийг санаачлагч оюутан байх,
  - Тогтвортой ногоон хөгжлийг дэмжигч оюутан байх,
  - Насан туршийн боловсролыг эрхэмлэгч оюутан байх
  - Иргэнлэг, хүмүүнлэг дэлхийн иргэн оюутан байх гэсэн зорилтын

дор оюутан суралцагч нь хувь хүний хөгжлийн 4 чадамж (Мэдлэг оюуны чадамж, Ногоон хөгжлийн чадамж, Хувь хүний хөгжлийн чадамж, Нийгмийн оролцооны чадамж), 16 дэд чадварыг эзэмшсэн дээд боловсролтой өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх эрмэлзэлтэй судлаач, бүтээлч оюутныг бэлтгэн гаргахаар заасныг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Жил бүр оюутанд туслах үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлгээ дүгнэлт өгч ажиллаж ирсэн. Суралцагчдын сургуульдаа хэр сэтгэл ханамжтайг асуухад судалгаанд хамрагдагчдын 38.3% сайн, 36.5% дунд, 24.7% нь муу, хичээлийн туслах ажилтан зөвлөх багшид 49.5% нь сайн, 30.6% нь дунд, 19.5% нь сэтгэл ханамжгүй гэсэн үнэлгээ өгсөн байна. Дээрх сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна. Бүрэлдэхүүн сургуулийн ном бүрдүүлэлтэд анхаарч сургууль дээр хэрэгжсэн Жайка ОУБ-ын “МАА, мал эмнэлгийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2016 оноос хойш хэвлэгдсэн мэргэжлийн чиглэлийн 57 нэр төрлийн 378 ширхэг 104.700.551 төгрөгийн англи хэл дээр бичигдсэн ном, сурах бичгийг захиалан авч номын фондоо баяжуулсан.
- МЭС-ийн оюутны холбоо, номын сан, ажлын төлөвлөгөө тайлангаа сургалтын албаар баталгаажуулж үнэлүүлдэг. Зөвлөх багшийн ангитай ажилласан ажлын тайланг мэргэжлийн тэнхмээр батлуулж үнэлүүлдэг ба түүнд үндэслэн 25 оюутан тутамд 1 хүртэл багц цагийг тооцдог.

- МЭС-ийн багш нар судалгааны ажил, төсөл хөтөлбөртөө бакалаврын оюутнуудыг оролцуулахаас гадна оюутны клиник сургалт, үйлдвэрлэлийн дадлага, эрдэм шинжилгээний дугуйланг чиглүүлэх, бүрэлдэхүүн, их сургууль, үндэсний болон олон улсын хэмжээний хурал, олимпиадад оюутнуудыг оролцуулах үйл ажиллагааг биечлэн удирдаж ажилладаг.
- Багш нарын удирдсан судлаач оюутнууд бүрэлдэхүүн сургуулийн санхүүжилтээр жил бүр зохион байгуулдаг төрийн соёрхолт, академич М.Төмөржавын нэрэмжит ЭШБ хурал, Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтарсан “Бүтээлч судлаач оюутан” ЭШБ хурал, Хурдан морь сонирхогч залуусын “Морьтон клуб”-ын санаачилсан “Монгол адууны өв соёл” сэдэвт ЭШБ хурал, ХААИС-ийн бакалаврын оюутны шилдэг илтгэл шалгаруулах ЭШБ хуралд идэвхтэй оролцдог. Тухайлбал 2016-2017 онд сургуулийн хэмжээнд 10 нарийн мэргэжлийн судалгааны чиглэлээр 10 дугуйлан ажиллуулж, 124 оюутан хамрагдсан судалгаа байна.
- ХААИС-аас “Суралцагч бүрийг судлаач, бүтээлч болгох” зорилтыг хэрэгжүүлэх үүднээс бакалавр оюутнуудын төгсөлтийн ажлыг сурталчлах, ач холбогдлыг нь танин мэдүүлэх зорилгоор Их сургуулийн захирлын тушаалаар “Шилдэг судлаач төгсөгч” өргөмжлөл гардуулах ажлыг зохион байгуулдаг.
- Сүүлийн 5 жилд тус сургуулийн хэмжээнд оюутны ЭШХ-д давхардсан тоогоор 222 оюутан илтгэл хэлэлцүүлснээс 2018-2019 оны хичээлийн жилд 28.8 хувиар өссөн байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Анхаарах асуудал:**

- Оюутны сайн дурын ажлын үнэлгээний системтэй болоход анхаарах.

**Зөвлөмж:**

- Оюутны төгсөлтийн ажлыг удирдах чиглэлээр мал эмнэлгийн салбарын холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэн, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах тусгай журам боловсруулан хэрэгжүүлэх.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Монгол улсын Боловсролын тухай хууль, ХААИС-ийн оюутны хөгжил хөтөлбөр, бүрэлдэхүүн сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд оюутан суралцагчдыг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулж, тэдний сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажиллаж байна.
- ХААИС-ийн Оюутны холбоо, МЭС-ийн оюутны зөвлөл нь оюутнуудыг нийгэм, мэргэжилдээ өсөн дэвжихэд чиглэсэн олон талт ажиллагааг тогтмол явуулж байна. ХААИС-ийн Оюутны холбооны дэргэдэх Клубуудын нэгдсэн зөвлөл нь 2019 баталсан журмыг мөрдөн ажилладаг. Их сургуулиас болон МЭС клуб, сайн дурын үйл ажиллагааг дэмжиж төсөв мөнгө баталж өгөх, сургалт, семинар хурал зохион байгуулах анги танхим, сургалтын тоног төхөөрөмжөөр хангаж өгдөг.
- Их сургуулийн хэмжээнд оюутны 21 клуб, спортын 14 секц, дугуйлан ажиллаж байна.
- МЭС-ийн оюутны зөвлөл нь жил, улирлаар ажлын төлөвлөгөө гаргаж сургалтын албаар хянуулж, захирлаар баталгаажуулж ажилладаг. Жилийн эцэст ажлын тайлангаа сургалтын албанд хүлээлгэн өгдөг. ХААИС-ийн болон бүрэлдэхүүний 5 сургууль дээр эрдэм шинжилгээний чиглэлийн дугуйлангаас гадна хүмүүнлэг, илтгэх урлаг, мэтгэлцээн, утга зохиол, яруу найраг, хэл, спорт, урлагийн нийт 29

төрлийн клуб үйл ажиллагаа явуулдаг. МЭС дээр “Морьтон”, “Өсвөрийн нохой сонирхогчдын клуб” ажилладаг.

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн [www.oyutan-ajil.mn](http://www.oyutan-ajil.mn) нэгдсэн цахим хуудас нээн ажиллуулж, [www.jobs-student.edu.mn](http://www.jobs-student.edu.mn) цахим хаягаар дамжуулан зөвлөгөө, мэдээлэл хүргэдэг.
- Мал эмнэлгийн байгууллагуудаас төрөн гарсан алдартан, эрдэмтдээр лекц уншуулах, сурталчилгаа хийхийн зэрэгцээ тус сургуулийн ажлын байрны самбарт цагийн ажлын, төгсөгчдөд ажлын байрны талаарх мэдээлэл, зар гаргаж тусалдаг. Тухайлбал 2015 онд төгсөгчдийг ажлын байртай болгох, ажил эрхлэлтийг дээшлүүлэх зорилгоор 4 удаагийн семинар зохион байгуулж тухайн жилийн 130 төгсөгчөөс 82 (62 %) нь ажлын байртай болж байсан.
- МЭС-ийн мэргэжлийн тэнхимийн багш нар оюутан суралцагчдыг олимпиад, тэмцээн, уралдаанд судалгааны ажлынх нь чиглэлээр болон сонирхсон салбар ухаан, хичээлийн хүрээнд чиглүүлэн оролцуулдаг. Тус сургууль нь мэргэжлийн чиглэлийн улсын болон мини 3 олимпиадыг (Мал эмнэлгийн физиологи, Анатоми, Гистологи, Микробиологи, Иммунологи) зохион байгуулдаг.
- ХААИС-ийн захирлын тушаалаар сурлагын өндөр амжилт гарган суралцсан оюутанд сурлагын төлбөрийн 20 хувийн хөнгөлөлт, Захирлын нэрэмжит батламж олгодог. Тухайлбал 2015-2019 онд нийт 309 оюутан захирлын нэрэмжит батламж авч, 52 оюутан сургалтын төлбөрийн 20-50 хувийн хөнгөлөлтөд хамрагдаж, хөдөө орон нутгаас ирсэн, явсан замын зардлын зардлын хөнгөлөлтийг 813 оюутан авчээ.
- 2019 оны 11-р сарын 15-ны өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн, Ерөнхий сайдын тэтгэлэгт ХААИС-ийн 5 оюутан түүний дотор МЭС-ийн 3-р курсийн оюутан Э.Нандин-Эрдэнэ хамрагдсан байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- НХХЯ, БШУЯ-ны сайдын хамтран баталсан Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөрийн хүрээнд ХААИС-ийн Ректорын 2009 оны 11-р сарын 289 тоот тушаалаар ХААИС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулсан.

**Зөвлөмж:**

- МЭС-ийн дэргэдэх оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг сургуулийн төсөв тусган, оюутны зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж дэмжлэг үзүүлэх.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн суралцагчийн шилжих хөдөлгөөнийг “ХААИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5-д заасны дагуу зохицуулдаг. Сүүлийн 5 жилийн хугацаанд оюутнуудаас шилжилт хөдөлгөөний талаар ямар нэгэн гомдол, санал гараагүй байна.
- Журмын 5.2.3-д заасан нөхцөлийг хангасан оюутан ХААИС-д шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Шилжин ирэх оюутны элсэлтийн ерөнхий шалгалтын чиглэл тохирсон, дүйцүүлсэн нийт кредитийн зөрүү 12-оос ихгүй, элссэнээс хойш 1 улирал суралцсан, сурлагын үнэлгээний голч нь 2-оос доошгүй байх шаардлагыг хангасан тохиолдолд шилжүүлдэг. Төгсөх ангид оюутан шилжүүлэн

суралцуулахыг хориглодог. Шилжин явах ба шилжүүлэн суралцуулах тухай асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын хөтөлбөрийн эрхлэгч шийдвэрлэнэ. Шилжилт хөдөлгөөнийг үндсэн улирлын эхний долоо хоногт багтаан хийнэ.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Уг хөтөлбөр нь нийгэмд эрэлт хэрэгцээ их, хөрвөх чадвар сайтайн улмаас шилжиж ирж байгаа суралцагчийн тоо өндөр бөгөөд тэдгээрээс бакалаврын зэрэгтэй суралцагчид 16% эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд уг хөтөлбөрт өөр мэргэжлээс нийт 212 оюутан шилжин суралцсаны 34 нь бусад их, дээд сургууль төгссөн бакалаврын зэрэг эзэмшсэн суралцагчид байна.

**Зөвлөмж:**

- Бакалаврын зэрэгтэй элсэгчид, шилжин суралцагчдын өмнөх сургалтын хичээлийг дүйцүүлэхэд оюутанд хүндрэл бэрхшээл үүсдэг асуудлыг дүрэм журмын хүрээнд шийдвэрлэх хэрэгтэй байна.

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- “ХААИС-ийн бакалаврын сургалтын журам”-ын 9-д заасны дагуу төгсөлтийн үйл ажиллагааг төгсөлтийн салбар комисс зохион байгуулна.
- ХААИС-ийн бакалаврын диплом олголт нь БСШУЯ-ны шийдвэр, дүрэм, журам ба хуулийн хүрээнд явагддаг. Төгсөгчдийн дипломыг Монгол (кюри ба уйгуржин), Англи хэлээр хэвлэдэг. Амжилттай сурч дээд боловсролын бакалаврын зэргийн болзол хангасан оюутан төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн ХААИС-ийн захирлын тушаалаар төгссөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдэг олгодог.
- ХААИС нь судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд “8.1.4 ба 8.1.6”-д заасны дагуу оюутан бүр төгсөлтийн ажил бичиж хамгаална гэж бакалавр оюутны сургалтын журмын 9.3-д заасан байдаг. МЭС-ийн төгсөлтийн ажил бичиж хамгаалах журмыг тус сургуулийн Эрдмийн Зөвлөлийн 2019 оны 06-р сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан.
- Төгсөгчдийн дүнгийн хүснэгт, диплом, хавсралтын хуулбар, дүнгийн дэвтэр, тойрох хуудас, дүнгийн хуудсыг ХААИС-ийн архивд хүлээлгэн өгдөг. ХААИС-ийн төгсөлтийн шалгалтын төв комисс бүрэлдэхүүн сургуулиудын төгсөлтийн үйл ажиллагааг ерөнхий удирдлага, зохицуулалтаар хангаж ажилладаг.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** [Бүрэн хангасан](#)

#### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

##### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай,

**Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн захирлын 2017 оны 4-р сарын 20-ны 60 тоот тушаалаар “ХААИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу докторын зэрэгтэй багшийг нээлттэй сонгон шалгаруулалтаар ажилд авдаг байна.
- Тус сургуульд одоогоор 33 багш ажилладаг. Доктор зэрэгтэй багш 2015 онд нийт багшийн 54.5 хувийг эзэлж байсан бол 2019 онд 76.5 хувь хүрч өссөн байна. 2015-2019 оны хооронд 8 багш доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.
- ХААИС-ийн дээрх журмын дагуу багшийн сургалтын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тооцохдоо дадлага 25, лаборатори 20, мэргэшүүлэх лаборатори 15 оюутантай байх норматив баримталдаг.
- Нэг багшид ногдох оюутны тоо 2015 онд 28 байсан бол 2016-2019 онд дунджаар 23 оюутан байна. Үүнээс авч үзвэл тус хөтөлбөрөөр суралцагчдад багш нэг бүр хүрч ажиллах боломжоор дутмаг байна.
- Багшийн албан тушаалыг 5 шатлал бүхий зэрэглэлийн ангилалд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулдаг. Багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 5 зэрэглэлтэй бөгөөд зэрэглэл тус бүрд тавигдах шаардлагыг ажлын байрны тодорхойлолтод ерөнхий болон тусгай шаардлагаар тогтоож өгдөг байна.
- Тус сургуульд профессор 6 хувь, дэд проф 21 хувь, ахлах багш 49 хувь, багш 9 хувь, дадлагажигч багш 15 хувиар багшийн зэрэглэлийн ангилалд нийцсэн шаардлагыг хангаж байгаа судалгаа байна.
- Профессор багшийн нэг хичээлийн жилд гүйцэтгэх ажлын норм 25 багц цаг байх ба албан тушаалын зэрэглэлээс хамаарч “А”, “Б” багц цагийн нэг хичээлийн жилийн норм, холбогдох журмаар ажилладаг байна.
- Багшийн цагийн ачааллыг тооцсон сүүлийн 5 жилийн судалгааг гаргасан байна. Тус судалгаанаас авч үзэхэд сүүлийн 5 жилд багш нар үндсэн кредит цагийн нормоос 50 хувиас дээш, зарим багш 100 хувиар илүү кредит цаг гүйцэтгэсэн байна. Үүнээс авч үзвэл нэг багшид ногдох цагийн ачааллыг багасгах, багш өөрийгөө хөгжүүлэх, оюутантай ажиллах цаг хугацааг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.
- Багш нарын урамшуулал нь ХААИС-ийн “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд (А) Сургалт, заах арга зүйн үйлчилгээ, (Б) Эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйлчилгээ, (В) Багшийн хөгжил, чадамжийн үйлчилгээ гэсэн 3 чиглэлээр шилдэг багшийг шалгаруулж урамшуулдаг ажээ.
- Жил бүр дээрх 3 чиглэлээр ХААИС-ийн оны шилдэг тэнхим, багшийг “Багш нарын баяр”-аар 3 шатлалаар шалгаруулж нийтэд сурталчилдаг. Тухайлбал, оны шилдэг сурган хүмүүжүүлэгч 2.000.000 төгрөг, шилдэг судлаач багш 2.000.000 төг, шилдэг залуу багш 1.500.000 төгрөгийн мөнгөн урамшуулал авдаг байна.
- Мөн тухайн жил доктор хамгаалсан багш 100.000 төгрөг, олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг имфакт фактортой сэтгүүлд өгүүлэл хэвлүүлбэл сэтгүүлийн төлбөр 50-100 хувь хөнгөлдөг зэрэг урамшуулал авдаг ажээ.
- Сүүлийн 5 жилд тус сургуулиас ХААИС-ийн түвшинд оны шилдэг сурган хүмүүжүүлэгчээр 3 багш, шилдэг судлаач багшаар 3 багш, олон улсын сэтгүүлийн хөнгөлөлт 2 багш, Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгийн шагнал 5 жилд давхардсан тоогоор 36 багш, ажилтан авсан нь судалгаагаар тогтоогдож байна.
- Багш нар жил бүр илүү гүйцэтгэсэн кредит цагийн хөлсийг зохих журмын дагуу авдгийн зэрэгцээ докторантурт суралцах, гадаад хэл, мэдээлэл зүй, мэргэжлийн ахисан түвшний сургалтад оролцоход төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

### Онцлог зүйл/Туршлага:

- Сургуульд доктор (PhD)-ын зэрэг хамгаалсан залуу багш нар олонх болсон нь сургалтыг шинэлэг арга хэлбэрээр орчин үеийн мэдээлэл технологийн дэвшлийг ашиглан сургалт явуулахад илүү давуу талтай байна.

### Анхаарах асуудал:

- Нэг багшид ногдох цагийн ачаалал харьцангуй их, багш өөрийгөө хөгжүүлэх, оюутантай ажиллах цаг бага, оюутныг хөгжүүлэхэд заавар, зөвлөмж, мэдээллээр хангах, зөвлөн туслах үйлчилгээ дутмаг.

### Зөвлөмж:

- Багшийн орон тоог нэмэгдүүлж, нэг багшид ногдох цагийн ачааллыг багасгах, багш нарын нийгэмд чиглэсэн үйлчилгээ, судалгаа шинжилгээ хийх, төгсөгчдийн практик ур чадварыг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг илүү өргөжүүлэх.

## 6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### Илрэл нотолгоо:

- ХААИС-аас “Багшийн хөгжил” хөтөлбөрийг анх 2002 онд боловсруулж гарган улмаар 2010, 2018 онуудад шинэчлэн батлуулж хэрэгжүүлж байна.
- Багшийн хөгжлийн цогц чадамжийн чиглэлээр 2018, 2019 онд багшийн суралцах хэрэгцээг тодорхойлох судалгаа гаргаж, уг судалгааны дагуу арга хэмжээ авч иржээ.
- Багш нар сүүлийн 5 жилд гадаад хэлний 37, мэдээллийн технологи цахим хичээл бэлтгэх 20, сурган заах арга зүйн ур чадвар 35, судалгааны арга зүй, төсөл хөтөлбөр боловсруулах 92 сургалтад хамрагдан мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байна.
- Багш нар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн зорилго, зорилтуудад тусгасан сургахуйн чадамж, судалгааны чадамж, мэдлэг, оюуны чадамж, хувь хүний чадамж гэсэн үндсэн 4 бүлэг чиглэлээр албан тушаалын зэрэглэлд нийцүүлэн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж тэнхимийн эрхлэгчээр батлуулан мөрдөж ажилладаг. Багш нар жилийн эцэст хийсэн ажлаа “Өөрийн үнэлгээний тайлан” хэлбэрээр бичиж тэнхимдээ хэлэлцүүлж ажлаа дүгнүүлж тайлагнадаг.
- Багш, оюутны практик ур чадварыг дээшлүүлэх, сайн туршлага эзэмших зорилгоор Японы Хоккайдогойн их сургуультай хамтран үндсэн мэргэжлийн 15 хичээлээр ДМАЭМБ-ын “Twinning program” амжилттай хэрэгжүүлжээ.
- 2015 оноос 8 залуу багш гадаад, дотоодод докторын зэргээ хамгаалсан байна. Мөн одоо 7 багш Япон, Унгар, БНХАУ-д докторантурт суралцаж буй ажээ. Нийт дүнгээр 2015 оноос хойших 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор гадаадын 9 оронд 38 багш, дотоодод 68 багшийг урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа байна.

### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

### Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутны практик ур чадварыг дээшлүүлэх, сайн туршлага эзэмших зорилгоор Японы Хоккайдогойн их сургуультай хамтран үндсэн мэргэжлийн 15 хичээлээр ДМАЭМБ-ын “Twinning program” амжилттай хэрэгжүүлсэн нь шинэ туршлага юм.

### 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн багш нар 5 жилд нийт 25 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж судалгааны ажлын үр дүнгээр нийт 12 зохиогчийн эрх, ашигтай загвар авсан байна.
- Хөдөө аж ахуйн их сургууль нь “Судалгааны их сургууль” болох зорилгын хүрээнд суралцагч бүрийг судлаач, профессор багш бүр судалгаанд суурилж, мэдлэгт түшиглэсэн технологийн эзэн байх гэсэн томоохон зорилт тавин ажиллаж байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр УИХ-аас баталсан хууль, бодлого, засгийн газраас баталсан журмууд, БСШУ-ны сайдын тушаалаар баталсан журам, аргачлал, ХААИС-ийн захирлын тушаалаар баталсан дүрэм, журмуудыг гарын авлага хэлбэрээр хэвлэн багш нарт олгон, хэрэгжилтийг ханган ажилладаг байна.
- МЭС-ийн профессор багш нар сургалтын үйл ажиллагаанаас гадна мал эмнэлгийн салбар чиглэлүүдээр төсөл бичиж Шинжлэх ухаан технологийн сан, ХААИС-ийн эрдэм шинжилгээний алба, Мал эмнэлгийн ерөнхий газар, JICA, KOICA, Швейцарын хөгжлийн агентлаг, Олон улсын шинжлэх ухааны сан зэрэг дотоод, гадаадын санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран 2015 оноос хойш нийт 25 төсөл, судалгааны ажил хэрэгжүүлсэн байна.
- ХААИС-ийн захирлын 2013 оны 12-р сарын 26-ны өдрийн 404 тоот тушаалаар тус сургуульд профессорын 4 баг байгуулан өнөөг хүртэл үр дүнтэй ажиллаж ирсэн байна.
- Сүүлийн 5 жилд ном, сурах бичиг 31, гарын авлага 31, редакторласан ном, гарын авлага 13-ыг тус тус боловсруулж хэвлүүлэн сургалт, судалгаанд ашиглаж байна. Мөн гадаадын имфакт фактортой сэтгүүлд 36, дотоодын шинжлэх ухааны сэтгүүлд 186 өгүүлэл нийтлүүлсэн байна.
- Тус хөтөлбөрийн сургалт нь дадлагад илүү суурилсан учраас оюутан суралцагч бүрийг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйд сургах, судалгаа хийлгэж, багш нар нь удирдан чиглүүлж ажиллаж байна.

#### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### Онцлог зүйл/Туршлага:

- Залуу багш нар Япон, Солонгос, Унгар, Хятад зэрэг өндөр хөгжилтэй орнуудад эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, молекул биологийн нарийн арга зүй эзэмшин эрдмийн зэрэг хамгаалж, улмаар төрөлх сургуульдаа багшилж байгаа нь дэлхийн хөгжлөөс суралцахад илүү давуу тал, сайн туршлага болж байна.

#### Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв, судалгаанаас гарсан үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлсэн туршлага тодорхой бус байгаад анхаарах.

#### Зөвлөмж:

- Судалгааны ажлын зардал, үр ашиг, практик хэрэглээнд нэвтрүүлэх төлөвлөгөө тооцоог нарийвчлан хийж хэвшил болгох.

### 6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.



### **Илрэл нотолгоо:**

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх талаар ХААИС-ийн профессор багшийн ажиллах журам, Профессор багшийг аттестатчилах журам, Багшийн хөгжил хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгүүдтэй байна.
- Дээрх бодлогын баримт бичиг, журмын дагуу “Багшийн өөрийн үнэлгээний тайлан” жил бүр бичиж үнэлж дүгнэдэг. Өөрийн үнэлгээний тайланг үндсэн 4 чиглэлээр бичиж өөрийгөө 1-5 баллаар дүгнэж, тэнхимд хэлэлцүүлэн үнэлгээ авахын зэрэгцээ сургуулийн удирдлагаас үнэлгээ авч ажилладаг байна. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд багш нарын өөрийн үнэлгээний дүнг сүүлийн 5 жилээр гаргасан байна.
- Багш нарт аттестатчиллыг 2 хэлбэрээр явуулдаг. Үүнд:1. Өөрийн үнэлгээ, 2. Хөндлөнгийн үнэлгээ. Багш зэрэглэлээс хамаарч 2-3 жил, 3-5 жилээр хөндлөнгийн аттестатчилалд ордог.
- Мөн оюутны сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнд дүгнэлт хийж ажилладаг байна. Тухайлбал, 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн 146 оюутнаас 3 бүлэг 46 асуултаар судалгаа авч 1-5 оноогоор сэтгэл ханамжийн судалгаа авахад багшийн мэдлэг, ур чадварт дунджаар 4.1 оноо, багшийн заах арга зүй 3.95 оноо, харилцаа, хандлага 3.89 оноо авсан үзүүлэлт байна.
- Багш нарын заах арга зүйг сайжруулах зорилгоор “Заах арга зүйн зөвлөл” ажилладаг.Тухайлбал, 2015-2019 оны 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 81 удаа залуу болон гэрээт багш нарын хичээлд заах аргын зөвлөлөөс ахмад туршлагатай багш нар сууж заавар, зөвлөмж өгч ажилласан байна.
- Мөн Япон, Англи зэрэг орнуудын хамтын ажиллагаатай сургуулийн профессор багш нарыг урьж авчран багш нарын дунд сургалт, семинар зохион байгуулах, оюутнуудад хичээл заалгаж тэдний сургалтын арга зүйгээс суралцаж буй ажээ.
- Багшийн үйл ажиллагааны баримт материалд хичээлийн сургалтын стандарт, төлөвлөгөө, цахим хичээлийн иж бүрдэл, конспект, гарын авлага, журнал, ажлын төлөвлөгөө, өөрийн үнэлгээний тайлан, бичсэн ном, сурах бичиг, өгүүлэл, оролцсон төсөл, хөтөлбөр, бусад бүтээлч ажил зэрэг материалууд хамаардаг бөгөөд цахим хэлбэрт орсон байна.

### **Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Өндөр хөгжилтэй орнуудын ижил хөтөлбөрийн профессор багш нартай харилцаа холбоо тогтоож, сургуульдаа урьж тодорхой чиглэлээр хичээл заалгаж сургалт, заах аргын ур чадвараа сайжруулж байгаа нь багш, оюутнуудад сонирхолтой онцлог ажил байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн хавтас бүрдүүлэлтийн чанар харилцан адилгүй, хичээлийн хөтөлбөр, лекцийн, тестийн материал зэргээс эхлээд засаж сайжруулах зүйлүүд байна.
- Багшлах бүрэлдэхүүнд сүүлийн жилүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй. Сургуулийн хөндлөнгийн үнэлгээний журам хүчин төгөлдөр бус байна.

#### **Зөвлөмж:**

- Багшийн хавтас бүрдүүлэлтийг нэгдсэн загварт оруулан үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу тавигдах шаардлагуудыг тодорхойлж хэрэгжилтийн хангахад анхаарч ажиллах.
- Хөндлөнгийн үнэлгээний журмыг холбогдох эрх зүйн баримт бичигтэй нийцүүлэн шинэчлэн баталгаажуулж тодорхой хугацаанд багш нарт үнэлгээ

хийж ажлын үр дүн, амжилт, сургамжийг тодорхойлж багшийн зэрэглэлийг тогтоож байх.

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** [Бүрэн хангасан](#)

## **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мал эмнэл зүй хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, үе шат ямар байхыг тодорхойлж, ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам, чанарын баталгаажуулалтын журам, хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг баталсан тушаалыг тус тус гаргасан байна.
- Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа нь хөтөлбөрийн хороодын үйл ажиллагаанд үндэслэсэн байна. Тодруулбал ХААИС, бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн түвшинд хөтөлбөрийн хороо зохион байгуулагдаж хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Хэсэгчлэн хангасан](#)

#### **Анхаарах асуудал:**

- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөө буюу хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд, тэр дундаа суралцахуйн үр дүнгүүдийг хэрхэн үнэлэх арга зүй, төлөвлөлт, зорилтот түвшин, үнэлгээний давтамж зэргийг нарийн тусгасан төлөвлөгөө, түүнийг 2014 оноос хойш хэрхэн хэрэгжүүлж ирсэн үр дүн хангалтгүй байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэл болон ач холбогдол, сургалтын орчин, нөөц, багш нарын чадамж зэрэг гол гол үзүүлэлтийг оролцогч талуудыг тусламжтай хэрхэн үнэлсэн талаар тодорхой хэмжигдэхүйц үр дүн харагдахгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөө буюу сургалтын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгийг үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу үнэлэх иж бүрэн загварыг бий болгох, түүнийгээ хэрэгжүүлэх талд анхаарч ажиллах.

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- 2015-2019 оны төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 662 төгсөгчийг хамруулан авсан байна. Мэргэжлээрээ ажил эрхлэлт 94% байна гэж тодорхойлжээ.

- Карьер өсөлтийн судалгааг 10 аймгийн мал эмнэлгийн алба, 50 сумын мал эмнэлгийн тасаг болон Мал эмнэлгийн хүрээлэн, Монгол Ви.И.Ти.Нет ТББ-ыг тус тус хамруулан авсан байна. Судалгаагаар дунджаар 3-5 жилийн хугацаанд албан тушаал дэвшиж байгааг тодорхойлжээ.
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгааг сүүлийн 5 жилийн 169 төгсөгчийг хамруулан авсан байна. Үр дүнгээс харахад төгсөгч дунджаар 4.8 сар хүлээж байж ажлын байраар хангагдаж байсан байна.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг 348 оюутан/56.6% маш сайн, 30.7% сайн/, төгсөгч оюутан/59.7% хангалттай, 30.7% дунд/, 30 ажил олгогчоос/39% ханамжтай, 47% дунд / тус тус авч үр дүнг боловсруулан тайланд тусгасан байна.

### Шалгуурыг хангасан байдал: [Бүрэн хангасан](#)

#### Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрийн төгсөгчдөөс Мал эмнэлгийн салбарт хөдөлмөрийн баатар 1, ардын багш 1, төрийн шагналтан 17, гавьяат багш 4, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн 3, малын гавьяат эмч 29, төр нийгмийн зүтгэлтэн 24 төрөн гарсан бөгөөд Монгол улсад хийгдсэн 6 шинэ нээлтийн эздээс 4 нь малын эмч байгаа нь хөтөлбөрийн чанар, үр дүнг илтгэх нэг үзүүлэлт гэж үзэж байна.

#### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлийг тус бүрээр нь үнэлэх зорилгоор авсан судалгаа, дүн шинжилгээ байхгүй байна. /Энэ шалгууртай холбоотойгоор мэргэжлийн салбар дахь хөтөлбөрийн ерөнхий ач холбогдол, төгсөгчдийн онцлог амжилтыг л дурдсан байна./

#### Зөвлөмж:

- Оролцогч талуудын шууд ба шууд бус үнэлгээгээр хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийн ач холбогдол болон гүйцэтгэлийн түвшнийг үнэлж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах.

### 7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- 2003 онд анх удаагаа магадлан итгэмжлэгдсэн. 2012 онд 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдэх үед БМИҮЗ-ээс өгсөн санал зөвлөмжийн дагуу сургалтын орчин, тоног төхөөрөмжийг шинэчлэх, багш нарыг чадавхжуулах, сургалтад шинэ технологи нэвтрүүлэх, номын сангийн хүртээмж, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлүүдэд сайжруулалт хийж ахиц дэвшил гарсан байна.
- 2012 онд Европын холбооны мал эмнэлгийн сургуулиудыг магадлан итгэмжлэх холбоогоор хөндлөнгийн үнэлгээ хийлгэж санал зөвлөмж авсан ба үүнд үндэслэн Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хөтөлбөрийг сайжруулах ажлыг хэрэгжүүлсэн байна.
- Мөн JICA байгууллагын тусламжтай хөтөлбөрт дахин хөндлөнгийн үнэлгээ хийлгэж үр дүнг үндэслэн сайжруулсан хөтөлбөрийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

- Мал эмнэлэг, эрүүл мэндийн тухай хуулийн 30.1 заалт, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын дагуу энэ чиглэлд үйл ажиллагаа явуулахын тулд заавал итгэмжлэл авах ёстой. 2013-2019 оны хооронд 897 малын эмч мал эмчлэх, 304 малын эмч эмийн сангийн үйлчилгээ эрхлэх итгэмжлэл авсан байна.
- Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо, Монгол ВИ.И.ТИ.НЕТ төрийн бус байгууллага, Монголын жижиг амьтны малын эмч нарын холбоо зэрэг байгууллагатай судалгаа шинжилгээ, сургалт, оюутны дадлага, хамтарсан хурал зөвлөгөөн зохион байгуулах зэрэг чиглэлүүдээр хамтран ажиллаж ирсэн туршлага байна.
- 2015-2019 онд нийт 913 бакалавр төгссөн бол 248 хүн магистрт дэвшин суралцсан байна. Энэ хугацаанд гадаадад 11 хүн магистрт, 27 хүн докторт суралцсан байна.

**Шалгуурыг хангасан байдал:** [Бүрэн хангасан](#)

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрт удаа дараа олон улсын түвшинд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж сайжруулж ирсэн туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**Зөвлөмж:**

- Цаашид төгсөгчдийн D1C чадамжийн хүрсэн түвшин ямар байгааг олон улсын түвшинд үнэлүүлэх талд бодлого гаргаж ажиллах нь зүйтэй.

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** [Бүрэн хангасан](#)

## ДҮГНЭЛТ

ХААИС-ийн МЭС-ийн “Мал эмнэл зүй” хөтөлбөрт шинжээчдийн зүгээс дараах нэгдсэн үнэлгээг өгч байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	7.1		Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо буюу сургалтын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгийг үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу үнэлэх арга зүй, төлөвлөгөө гараагүй, хэрэгжүүлэлт хангалтгүй.
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС-ийн МЭС-ийн “Мал эмнэл зүй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../ Н.Эрдэнэхүү/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Б.Энхтөр/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Д.Наранмандах/

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

<b>Сургуулийн нэр</b>	<b>ХААИС-ийн МЭС</b>
<b>Хөтөлбөрийн нэр</b>	<b>“Мал эмнэл зүй”</b>
<b>Хөтөлбөрийн индекс</b>	<b>D084101</b>
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн төгсөгчийн загвар, Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs), D1C чадамжийн жагсаалт буюу хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs), хичээлийн суралцахуйн үр дүнгүүд(CLOs) хоорондын уялдаа холбоог тодорхой гаргаж багш, оюутнуудад ойлгуулах, сургалтын үйл ажиллагааг эдгээр үр дүнг оюутанд эзэмшүүлэхэд чиглүүлэх.</li> <li>• PEOs, PLOs буюу суралцахуйн үр дүнгүүдийг оюутны гарын авлага, веб сайт зэрэг мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд түгээж таниулдаг байх.</li> <li>• 2019 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөр нь магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан хэлбэртэй байгаад дүгнэлт хийж сургалтын үйл ажиллагааны циклийг илэрхийлсэн төлөвлөлтийн бичиг баримт талаас нь харж засаж сайжруулах.</li> <li>• Хичээлийн хавтас бүрдүүлэлтэд хичээлийн хөтөлбөр, лекцийн материалаас гадна лабораторийн заавар, явцын болон улирлын шалгалтын материал, бие даалтын удирдамж, ашиглах ном сурах бичгийн жагсаалт, бусад хэрэглэгдэхүүний талын мэдээллийг бүрэн оруулах, эдгээр бичиг баримтын төлөвлөлтийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу боловсруулах.</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• D1C чадамжийн жагсаалт буюу хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs)-ийн дэлгэрэнгүй жагсаалтыг сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээл бүртэй нэг бүрчлэн холбох замаар PLOs ба хичээл хоорондын хамаарлыг нарийн гаргах. Энэ хамаарлаас хичээлийн CLOs-ийг гаргах.</li> <li>• Цаашид хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг багш хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүй боловсруулж гарын авлага гаргах, түүнийг багш нарт зааж эзэмшүүлэх, хэрэгжүүлэх.</li> <li>• Хөтөлбөрт мал эмнэлгийн уламжлалт эмчилгээ, оношилгооны арга технологийг зөв зохистой харьцаагаар оруулж, Монгол мал, Монгол эм, эмчилгээ, Монгол мэргэжилтэн гэсэн онцлогийг хадгалахад анхаарч ажиллах.</li> <li>• Оюутнууд мал, амьтан дээр дадлага хийх, өвчний оношилгоо, шинжилгээний дээж авах, лабораторийн ажлыг гардан хийх, эмчилгээ, тусламжийн арга хэлбэр, практик ур чадварыг эзэмших дадлага, лабораторийн хичээлийн чанарыг эрс сайжруулах.</li> <li>• Хөдөө орон нутагт хийж буй сургалт, үйлдвэрлэлийн дадлагуудын төлөвлөлт, удирдамжийг шинэчлэх, чанаржуулах, удирдагч багшийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.</li> <li>• “Мэргэжлийн англи хэл”-ний хичээлийг мал эмнэлгийн мэргэжлийн багшаар заалгаж хичээлийн үр дүнг дээшлүүлэх.</li> </ul>

<p>Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Нэр бүхий лабораториудыг албан ёсны баталгаажуулах эрхтэй болгох үүднээс Стандарт хэмжил зүйн газар, Үндэсний итгэмжлэлийн төв болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаар тохирлын үнэлгээ, баталгаажуулалт хийлгүүлж “Итгэмжлэгдсэн лаборатори” -ийн эрхтэй болох.</li> <li>• Өндөр хүчин чадлын баталгаажуулах түвшний лабораториудыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах, сургууль, тэнхимд орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор “Бизнес төлөвлөгөө” боловсруулж ажиллах.</li> <li>• Сургуулийн цайны газар, хэвлэх цех, манежны өрөөнд засвар үйлчилгээ хийж агааржуулалт, эрүүл ахуйн шаардлага, орчин нөхцөлийг сайжруулах.</li> <li>• Сургуулийн ариун цэврийн өрөөнд иж бүрэн засвар хийж эмэгтэй, эрэгтэйгээр нь тусгаарлах, агааржуулалт болон угаалтуур нэмэгдүүлж, эрүүл ахуйн орчин нөхцөл, тав тухтай байдлыг хангаж сайжруулах.</li> <li>• Цаашид тус сургуулийн хичээлийн байранд иж бүрэн их засвар хийх, эсвэл шинээр хичээлийн байр барих асуудлыг төр засгийн бодлогын түвшинд тавьж шийдвэрлэх.</li> <li>• Цахим номын фондыг 2015 оноос хойш хэвлэгдсэн, мэргэжлийн чиглэлийн Англи хэл дээр цахим номоор баяжуулах.</li> <li>• Номын санч болон багш нар оюутнуудад цахим ном хэрхэн ашиглах талаар сургалт өгч, заавар зөвлөмжөөр хангах.</li> </ul>
<p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тус сургуулийн “Мал эмнэл зүй” хөтөлбөрийг 4 тэнхим хамтран хэрэгжүүлж байгаа хэдий ч хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихад тэнхимүүдийн оролцоо, хамтын ажиллагаа сул, зөвхөн сургалтын албаны ажил мэтээр хандаж байгаад дүгнэлт хийж, цаашид тэнхимүүд хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болох.</li> <li>• МЭС-ийн Төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.</li> <li>• Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нийгэмд байгаа бодит асуудлуудыг шийдэхэд багш, оюутнуудыг татан оролцуулах талд анхаарах.</li> </ul>
<p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Элсэгчдийн чанарыг дээшлүүлэх зорилгоор ХААЯ, БШУЯ-тай хамтран ажиллаж бодлогын дэмжлэг авах талд санаачилга гарган ажиллах.</li> <li>• Малын бага эмчээр төгсөгчдөөс МЭС-д дэвшин суралцах үйл ажиллагааг зохицуулах, мөн бакалаврын зэрэгтэй элсэгчид, их дээд сургуулиас шилжин суралцагчдын өмнөх сургалтын хичээлийг дүйцүүлэх асуудлыг зохицуулах дүрэм, журам боловсруулж мөрдөх.</li> <li>• Оюутны төгсөлтийн ажлыг удирдах чиглэлээр мал эмнэлгийн салбарын холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэн, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах тусгай журам боловсруулан хэрэгжүүлэх.</li> </ul>
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багшийн орон тоог нэмэгдүүлж, нэг багшид ногдох цагийн ачааллыг багасгах, багш нарын нийгэмд чиглэсэн үйлчилгээ, судалгаа шинжилгээ хийх, төгсөгчдийн практик ур чадварыг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг илүү өргөжүүлэх.</li> <li>• Хөндлөнгийн үнэлгээний журмыг холбогдох эрх зүйн баримт бичигтэй нийцүүлэн шинэчлэн баталгаажуулж тодорхой хугацаанд багш нарт үнэлгээ хийж ажлын үр дүн, амжилт,</li> </ul>

	<p>сургамжийг тодорхойлж багшийн зэрэглэлийг тогтоож байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Жижиг амьтны (нохой, муур гм) өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөө буюу сургалтын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгийг үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу үнэлэх иж бүрэн загварыг бий болгох, түүнийгээ хэрэгжүүлэх талд анхаарч ажиллах.</li> <li>• Оролцогч талуудын шууд ба шууд бус үнэлгээгээр хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийн ач холбогдол болон гүйцэтгэлийн түвшнийг үнэлж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах.</li> <li>• Цаашид төгсөгчдийн D1C чадамжийн хүрсэн түвшин ямар байгааг олон улсын түвшинд үнэлүүлэх талд бодлого гаргаж ажиллах.</li> </ul>
<b>ШААРДЛАГА</b>	
7.1	<ul style="list-style-type: none"> <li>• Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх ерөнхий загвар боловсруулах.</li> <li>• Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг үнэлэх өөрийн үнэлгээний арга зүйг боловсруулах</li> <li>• Хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнг үнэлэх шууд ба шууд бус үнэлгээний төлөвлөгөөг гаргах</li> <li>• Дээрх төлөвлөлтийн дагуу бүх оролцогч талуудыг хамруулан хичээлээс хөтөлбөрийн түвшинд үнэлгээ хийж, үр дүнд шинжилгээ хийх.</li> <li>• Үнэлгээний үр дүнгээр улиралд, хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.</li> </ul>



#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	П. Болормаа	Профессор	Профессор	31	Эм судлал
2	Н. Очирхүү	Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд	Доктор (Ph.D)	10	Мал эмнэлгийн ажлын зохион байгуулалт
3	П. Ням-Осор	Тэнхимийн эрхлэгч	Доктор (Ph.D)	18	Мал эмнэлгийн ариун цэвэр магадлан шинжилгээ
4	Д. Дэлгэрмөрөн	Тэнхимийн эрхлэгч	Доктор	12	Эм судлал
5	Б. Баяртогтох	Дадлагажигч багш	Магистр	10	Дотрын өвчин судлал
6	С. Гэрэлт-Од	Багш	Магистр	15	Мал эмнэлгийн хууль, эрх зүй
7	Ж. Гэрэлтуяа	Дадлагажигч багш	Магистр	5	Онош судлал
8	Ч. Оюунцэцэг	Ахлах багш	Доктор	3	Физиологи
9	Б. Сандагдорж	Багш	Магистр	20	Малын эрүүл ахуй
10	Ч. Хоролмаа	Тэнхимийн эрхлэгч	Доктор	18	Физиологи
11	Ц. Ариунаа	Дадлагажигч багш	Магистр	15	Вирус судлал

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэр	Курс	Сонгосон байдал
1	Б. Даариймаа	1	Оюутны зөвлөлийн гишүүн
2	А. Насанжаргал	1	Оюутны зөвлөлийн гишүүн
3	Э. Батбаяр	1	Оюутны байранд амьдардаг
4	Б. Нарантуяа	2	Улаанбаатар хотоос элссэн
5	Г. Доржнамжаа	2	Оюутны клуб дугуйланд явдаг
6	Б. Оюундарь	3	Улаанбаатар хотоос элссэн
7	Б. Тайванжаргал	3	Орон нутгаас элссэн, Олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог
8	Д. Анужин	3	Олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог, Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцдог
9	А. Тэгшзаяа	3	Орон нутгаас элссэн
10	Д. Дүгэрсүрэн	4	Хөгжлийн бэрхшээлтэй
11	Ц. Даваажаргал	4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцдог
12	Э. Дөлгөөнзул	4	Улаанбаатар хотоос элссэн
13	Б. Нандин-Эрдэнэ	4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцдог
14	С. Нинжбулган	5	Шилдэг судлаач оюутан
15	Б. Баттулга	5	Олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог
16	Namfonh Vorasane	5	Гадаад оюутан

##### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Д. Батцэнгэл	Ховд аймгийн мал эмнэлгийн газар	Дарга
2	Б.Цолмон	“Биокомбинат” ТӨҮГ	Дарга
3	Б. Болдбаатар	Төв аймгийн мал эмнэлгийн газар	Дарга
4	Б. Батцэцэг	Мал эмнэлгийн хүрээлэн	Захирал
5	Б. Ганзориг	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори	Захирал

##### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Минжин	2016	Northern Dairy LLC төсөл	Дорнод Халх гол суманд хэрэгжиж байгаа төсөлд
2	Т.Мягмардулам	2016	Говь-Алтай Тонхил суманд	МЭ-н Улсын байцаагч
3	Ш.Бяхаржав	2016	Завхан Алдархаан	МЭ-н тасагт эмч
4	Б. Баяржаргал	2017	Аймгийн МЭ-ийн лаборатори	Малын эмч
5	Б. Мөнхсаран	2017	Глобаль Бизнес линк ХХК	Малын эмч
6	Д.Цэрэндолгор	2018	SOS Vet ХХК	Малын эмч
7	Ц.Пүрэвсүрэн	2018	Монгол В И Т Нет ТББ	Малын эмч
8	Ч.Сарантуяа	2019	Онцгой байдлын ерөнхий газар	Эрин хайх аврах нохойн алба малын эмч
9	М.Мөнхжаргал	2019	Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газар	Малын эмч
10	Б.Минжбадам	2020	Төв аймгийн мал эмнэлгийн газар	Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
**/албан бичгийг оруулах/**



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ**  
**МАЛ ЭМНЭЛГИЙН СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Зайсан-5  
11-р хороо, Утас: 7510-7777-212,  
И-мэйл: [veterinary@mul.edu.mn](mailto:veterinary@mul.edu.mn)  
Вэб сайт: <http://www.muls.edu.mn>

2024.01.14 № 06  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БМИҮЗ-ИЙН ШИНЖЭЭЧИЙН**  
**АЖЛЫН АЛБАНД**

ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн “Мал эмнэлзүй” бакалаврын сургалтын хөтөлбөрт хийсэн магадлан итгэмжлэх комиссын шинжээчийн багийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ



А.ГОМБОЖАВ

019503006

## ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн  
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**